



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН
БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.25 № 31-1/53
танай _____-ны № _____-т

Асуудал зөвшилцөх тухай

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын "Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ⁰⁹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264002255

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“16.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийн тухай

1. “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулах шаардлага

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2 дахь заалтад “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-г заавал Улсын Их Хурал соёрхон батлахаар заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулдаг хуулийн зохицуулалттай.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан, эдийн засгийн үр өгөөжтэй, Бүгд Найрамдах Австри Улс (цаашид “БНАУ” гэх)-ын санхүүжилтээр хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг тодорхойлж, хоёр тал санал солилцон, санхүүжилтийг баталгаажуулахаар “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг хамтран боловсруулаад байна.

БНАУ-ын Засгийн газраас Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (цаашид “ЭЗХАХБ” гэх)-ын дүрмийн дагуу Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн хүрээнд зээл олгодог бөгөөд Дэлхийн банкны үнэлгээгээр 2 жил дунджаас дээгүүр орлоготой орон болсон тохиолдолд хөнгөлөлттэй зээл ашиглах боломжтой орны тооноос хасагддаг. Монгол Улсын хувьд 2024 болон 2025 онуудад дунджаас дээгүүр орлоготой орон болсон тул ЭЗХАХБ-ын дүрмийн дагуу дахин хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр ашиглах боломжгүй болж байна.

Энэ хүрээнд БНАУ-ын Засгийн газраас авах хамгийн сүүлийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг 2025 оны 5 дугаар сард БНАУ-ын Ерөнхийлөгч Александр Ван Дер Беллений төрийн айлчлалын үеэр “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг үргэлжлүүлэх “Эрмэлзлийн захидал”-ыг хоёр талын Сангийн яам хооронд байгуулан баталгаажуулсан болно.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд нийт 65.0 сая еврогийн эх үүсвэрийг авч ашиглах боломжтой бөгөөд зээлийн эх үүсвэр нь 1 хувийн хүүтэй, 0.9 хувийн баталгааны шимтгэлтэй, 19 жилийн хугацаатай, эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй болно.

Цаашлаад “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг УИХ-аар соёрхон батлуулснаар хэлэлцээрийн эх үүсвэрийг заавал авч ашиглах үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь зээлийн гэрээ биш юм. Харин хэлэлцээрийг УИХ-аар соёрхон баталсан тохиолдолд БНАУ-тай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зээлийн гэрээ, хэлэлцээрийг байгуулж ажиллах боломжтой болно.

2. Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүдийн талаар

Засгийн газрын 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журам”-д заасны дагуу Сангийн яам салбарын сайд нараас зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслүүдийн саналыг хүлээн авсан бөгөөд нийт 97.8 сая еврогийн дүнтэй 10 төслийн санал ирсэн.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд ашиглах боломжтой эх үүсвэр хязгаарлагдмал тул төслүүдийг эдийн засаг, нийгмийн үр өгөөж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдлаар эрэмбэлүүлэхээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, тус яамнаас ирүүлсэн эрэмбийн дагуу БНАУ-ын талтай төслийн жагсаалтыг тохиролцож, дараах байдлаар “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийн хавсралтад тусгасан. Үүнд:

№	Төслийн нэр	Нийт зээлийн хэмжээ /сая евро/
1	Хорт хавдрын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл	10.0
2	Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулах	7.5
3	Монгол Улсад эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл	8.0
4	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	10.0
5	Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн гуравдугаар шатны төсөл	10.0
6	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ба хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах дараагийн шатны төсөл	9.5
7	Дуурь бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл	10.0
НИЙТ		65.0

3. Санхүүгийн хамтын ажиллагааны өмнөх хэлэлцээрүүдийн талаар

БНАУ-тай 2011, 2016, 2019 онд тус тус байгуулсан 3 удаагийн “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд нийт 120 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 16 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс 14 төсөл бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд үлдсэн 2 төсөл 2026 оны II улиралд хэрэгжиж дуусна.

Эрүүл мэндийн салбарт: Дээрх төслүүдээс нийт 74.5 (62%) сая еврогийн хэлэлцээрийн дүн бүхий 10 төсөл эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн. Тус салбар дахь нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах дэвшилтэт технологийн 662 нэр төрлийн 3,090 гаруй тоног төхөөрөмжийг улсын 8 эмнэлэгт нийлүүлсэн нь эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээг олон улсын стандартад хүргэх, орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлж, иргэдийн эрүүл мэнд, амьдрах нөхцөлийг сайжруулсан.

Цэвэр, бохир ус хангамж: Нийт 28.5 (24%) сая еврогийн хэлэлцээрийн дүн бүхий 3 төсөл Улаанбаатар хот, Дархан-Уул, Говь-Алтай аймагт хэрэгжсэн нь Алсын хараа-

2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 2025 онд 85 хувь, 2030 онд 87 хувь, 2050 он гэхэд 90 хувьд, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 2030 онд 75 хувь, 2050 он гэхэд 90 хувьд хүрэх” гэсэн зорилтыг биелүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Онцгой байдал, Дэд бүтэц – Гэрэлтүүлэг: Нийт 17.0 (14%) сая еврогийн хэлэлцээрийн дүн бүхий 3 төсөл хэрэгжсэн. Үүнд:

1. Онцгой байдлын ерөнхий газарт 19 ширхэг гал унтраах, аврах автомашинууд болон гал унтраах тусгай албаны автомеханик шат гэх мэт дагалдах тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн иж бүрдлүүдийг нийлүүлсэн;

2. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 34 хороонд нийт 6800 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан;

3. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 17 хороонд 3,057 ш, Дархан-Уул аймгийн 4 суманд 1406, Сэлэнгэ аймгийн 3 суманд 1350 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.

Зээлийн эргэн төлөлтийн хуваарийг хавсралт-1-д, хамтын ажиллагааны хүрээнд өмнө нь хэрэгжүүлсэн төслүүдийн хэрэгжилтийн талаар мэдээллийг хавсралт-2-т, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслүүдийн талаар мэдээллийг дүн шинжилгээний хамт хавсралт-3-т тус тус хавсаргав.

---o0o---

ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд Австрийн талаас дараах нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг санал болгож байна:

Зээлийн хүү: 1 хувийн хүүтэй,

Баталгааны шимтгэл: 0.9 хувийн баталгааны шимтгэлтэй,

Эргэн төлөх хугацаа: 19 жилийн хугацаатай, үүнээс эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй болно.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл бүр дээр тусгайлсан зээлийн хэлэлцээрүүд байгуулах бөгөөд тухайн хэлэлцээрийн хүрээнд өрийн үйлчилгээ хийгдэнэ.

Төсөл тус бүр дээр гарах ашиглалтыг урьдчилсан байдлаар тооцон эргэн төлөлтийн хуваарийг тооцсон тул төсөл хэрэгжих хугацаанд төлбөр өөрчлөгдөх магадлалтай.

Хүснэгт 1. Эргэн төлөлтийн хуваарь /евро/.

Жил	Хагас жил	Зээлийн үлдэгдэл	Ашиглалт	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
2027	1	-	13,700,000.00	-	-
	2	13,700,000.00	13,700,000.00	-	130,150.00
2028	3	27,400,000.00	17,525,000.00	-	260,300.00
	4	44,925,000.00	17,525,000.00	-	426,787.50
2029	5	62,450,000.00	1,275,000.00	-	593,275.00
	6	63,725,000.00	1,275,000.00	-	605,387.50
2030	7	65,000,000.00	-	-	617,500.00
	8	65,000,000.00	-	-	617,500.00
2031	9	65,000,000.00	-	2,166,666.67	617,500.00
	10	62,833,333.33	-	2,166,666.67	596,916.67
2032	11	60,666,666.67	-	2,166,666.67	576,333.33
	12	58,500,000.00	-	2,166,666.67	555,750.00
2033	13	56,333,333.33	-	2,166,666.67	535,166.67
	14	54,166,666.67	-	2,166,666.67	514,583.33
2034	15	52,000,000.00	-	2,166,666.67	494,000.00
	16	49,833,333.33	-	2,166,666.67	473,416.67
2035	17	47,666,666.67	-	2,166,666.67	452,833.33
	18	45,500,000.00	-	2,166,666.67	432,250.00
2036	19	43,333,333.33	-	2,166,666.67	411,666.67
	20	41,166,666.67	-	2,166,666.67	391,083.33
2037	21	39,000,000.00	-	2,166,666.67	370,500.00
	22	36,833,333.33	-	2,166,666.67	349,916.67
2038	23	34,666,666.67	-	2,166,666.67	329,333.33
	24	32,500,000.00	-	2,166,666.67	308,750.00
2039	25	30,333,333.33	-	2,166,666.67	288,166.67
	26	28,166,666.67	-	2,166,666.67	267,583.33

2040	27	26,000,000.00	-	2,166,666.67	247,000.00
	28	23,833,333.33	-	2,166,666.67	226,416.67
2041	29	21,666,666.67	-	2,166,666.67	205,833.33
	30	19,500,000.00	-	2,166,666.67	185,250.00
2042	31	17,333,333.33	-	2,166,666.67	164,666.67
	32	15,166,666.67	-	2,166,666.67	144,083.33
2043	33	13,000,000.00	-	2,166,666.67	123,500.00
	34	10,833,333.33	-	2,166,666.67	102,916.67
2044	35	8,666,666.67	-	2,166,666.67	82,333.33
	36	6,500,000.00	-	2,166,666.67	61,750.00
2045	37	4,333,333.33	-	2,166,666.67	41,166.67
	38	2,166,666.67	-	2,166,666.67	20,583.33
НИЙТ		65,000,000.00		65,000,000.00	12,822,150.00

• Зээлийн хүүгийн төлбөрийг ашигласан зээлийн дүнгээс тооцож төлөх бөгөөд 65.0 сая еврогийн эх үүсвэрт баталгааны шимтгэлтэй хамт жилийн 1.9 хувийн хүү төлнө. Хэлэлцээрийн хүрээнд нийт 12.8 сая еврог хүүгийн төлбөрт төлөхөөр байна.

• БНАУ-тай хэрэгжүүлэх төслүүд нь тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төсөл тул 2-3 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон бөгөөд зээлийн хөрөнгийг 2029 онд бүрэн ашиглаж дуусахаар байна.

Ашиглалтын төсөөлөл өөрчлөгдсөн тохиолдолд дээрх тооцоолол өөрчлөгдөнө.

---oOo---

**БНАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН “САНХҮҮГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮДИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

№	Төслүүд	Өртөг (сая евро)	Хэрэгжүүлэх байгууллага (хуучнаар)	Хэрэгжилт	Нэмэлт мэдээлэл
2011 онд байгуулсан МУЗГ, БНАУ хоорондын 40 сая еврогийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр					
1	Монгол Улсын Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл	7.0	ЭМЯ	100%	Туяа эмчилгээний болон дүрслэл оношилгоо, эмчилгээний 14 төрлийн 19 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд тоног төхөөрөмжийг ашиглах талаар холбогдох сургалтууд хийгдсэн.
2	Улаанбаатар хотын цэвэр, бохир усны хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл	7.0	НЗДТГ, УСУГ		Ус хангамжийн шугам сүлжээг шуудуу ухалгүйгээр сэргээн сайжруулах технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмж, нийт 44 км шугам, хоолой доторлох түүхий эд материал, худалдан авах, доторлох төлөвлөгөөний дагуу ханган нийлүүлэлтийн бүх ажил хийгдэж дууссан, шугам доторлогооны материал үе шаттайгаар нийлүүлэгдэж, доторлогооны ажил хийгдсэн.
3	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл	7.0	ЭМЯ		216 нэр төрлийн 1118 ширхэг оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авсан бөгөөд тоног төхөөрөмж суурилуулахтай холбоотой зарим засвар, шинэ тоног төхөөрөмжийг ашиглахтай холбоотой сургалтууд хийгдсэн.
4	Улсын нэгдүгээр эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төсөл	7.0	ЭМЯ		Дүрс оношилгоо, эрчимт эмчилгээ болон мэс заслын 43 нэр төрлийн 112 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд шинэ тоног төхөөрөмжийг ашиглахтай холбоотой сургалтууд хийгдсэн.
5	Төрийн тусгай албаны эмнэлэг төсөл (Цэргийн госпиталь эмнэлэг)	7.0	БХЯ		Цэргийн госпиталь эмнэлэгт лаборатори, дүрс оношилгоо, мэс засал, яаралтай тусламж эрчимт эмчилгээний 115 нэр төрлийн 315 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авсан.
6	Онцгой байдлын газрын гал унтраах техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах төсөл	5.0	ОБЕГ		19 ширхэг гал унтраах, аврах автомашинууд болон гал унтраах тусгай албаны автомеханик шат гэх мэт дагалдах тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн иж бүрдлүүдийг худалдан авсан.
2016 онд байгуулсан МУЗГ, БНАУ хоорондын 40 сая еврогийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр					
1	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг (ХЗДХЯ-ны эмнэлэг)	7.0	ХЗДХЯ	100%	Мэс засал, гэмтэл, нөхөн сэргээх мэс засал болон эмчилгээ, оношилгооны 180 гаруй төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авсан. Мөн тоног төхөөрөмжийг ашиглах талаар холбогдох сургалтууд хийгдсэн.
2	Дэд бүтцийн хөгжил - Сонгинохайрхайн дүүрэг	7.0	БХБЯ		Сонгинохайрхан дүүргийн 34 хороонд нийт 6800 ширхэг гэрэлтүүлгийг амжилттай суурилуулсан.
3	Тайшир-Алтай ус хангамж	14.0	БХБЯ		Холбогдох тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн. 54,900 м урт шугам хоолойн угсралт, Ус авах толгойн хэсэг, Ус цэвэршүүлэх байгууламжийн барилга, Дундын өргөлтийн насос станцын барилга, нөөц усны байгууламжийн барилга бүрэн хийгдсэн.

4	Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх дүүрэг, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг	5.0	БХБЯ		Баянзүрх дүүргийн 17 хороонд 3057, Дархан-Уул аймагт 4 суманд 1406, Сэлэнгэ аймагт 3 суманд 1350, Нийт 5813 ширхэг гэрэлтүүлгийг амжилттай суурилуулсан.
5	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	7.0	ЭМЯ		Төслийн хүрээнд 34 нэр төрлийн 814 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэгдсэн, суурилагдаж, ашиглалтад хүлээн авсан. Холбогдох эмч, мэргэжилтнүүд нарийн мэргэжлийн сургалтад бүрэн хамрагдсан.
2019 онд байгуулсан МУЗГ, БНАУ хоорондын 40 сая еврогийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр					
1	Хорт хавдрын навигаци болон стереотактик эмчилгээний төв байгуулах төсөл	7.0	ЭМЯ	100%	19 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, ХСҮТ-д хүлээлгэн өгсөн. Үүнд: Нейронавигацийн аппарат, Мэдрэлийн мэс заслын микроскоп, Хэт авиан долгионы тусламжтайгаар хавдрын эдийг буталж, соруулах аппарат, Өндөр хурдны ясны цахилгаан хөрөө, Коагуляцийн аппарат, Мэдрэлийн мэс заслын сандал, Толгой баригч систем, ретрактор систем, Стерео туяаны мэс засал эмчилгээ хийх өндөр нарийвчлал бүрхий шугаман хурдасгуур аппарат, Стереотактик эмчилгээний үед өвчтөнийг хөдөлгөөнгүй байлгах хэрэгсэл.
2	Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл (Цэргийн госпиталь эмнэлэг)	8.0	БХЯ	100%	Төслийн хүрээнд 8 нэр төрлийн 96 иж бүрдэл эмнэлгийн тоног төхөөрөмж, 3 нэр төрлийн 25 иж бүрдэл мэс заслын багаж хэрэгслийг хүлээн авсан.
3	АШУҮИС болон эмнэлгүүдийн тоног төхөөрөмж шинэчлэх төсөл	7.5	БШУЯ	100%	Төсөл 2024 оны I улиралд бүрэн хэрэгжиж дууссан. <ul style="list-style-type: none"> АШУҮИС-ийн төв эмнэлэгт 5.4 сая еврогийн дүн бүхий 70 нэр төрлийн, 84 тоног төхөөрөмж; Нүүр ам судлалын төв эмнэлэгт 0.9 сая еврогийн дүн бүхий 17 нэр төрлийн, 26 тоног төхөөрөмж; Монгол анагаах ухааны төв эмнэлэгт 5.4 сая еврогийн дүн бүхий 23 нэр төрлийн, 30 тоног төхөөрөмж. НИЙТ 84 нэр төрлийн, 143 тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.
4	Дархан хотын цэвэр усны сүлээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл	7.5	БХБЯ	90%	Төслийн хэрэгжилтийн явц: 99% Төслийн хүрээнд суурилуулах 13,300 м цэвэр усны уян хоолой 2026 оны 1 сард бүрэн суурилуулагдаж дууссан, 15,000 ширхэг ухаалаг тоолуур суурилуулах ажлыг улсын комисс хүлээж авахаар ажиллаж байна..
5	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах төсөл	10.0	ЭМЯ	90%	Төслийн хэрэгжилтийн явц: 99% Төслийн хүрээнд нийлүүлэгдэх тоног, төхөөрөмж 2025 оны 12 сард бүрэн нийлүүлэгдэж, суурилуулагдсан, 2026 оны 06 дугаар сард сүүлийн сургалт хийгдсэнээр төсөл бүрэн хэрэгжиж дуусна. Төслийн хүрээнд хийгдсэн ажил: <ul style="list-style-type: none"> Дуудах-Эргэн дуудах тогтолцооны цахим систем хөгжүүлэлт, тоног төхөөрөмж (www.screening.gov.mn) Хүний нөөцийн чадавхжуулах сургалт (30 газар, 5 чиглэлээр, 2-3 удаагийн давтамжтай сургалт)

**“ХОРТ ХАВДРЫН НЕЙРОНАВИГАЦ, СТЕРЕОТАКТИК ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/273 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ын “А-1” заалтыг хасах нөхцөлийг бүрдүүлэн, мэдрэлийн мэс заслын нейронавигаци, стереотактик оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нэн шаардлагатай төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулах зорилготой бөгөөд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Мэдрэлийн мэс заслын нейронавигаци, стереотактик оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нэн шаардлагатай 30 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулах;
- РЕТ-СТ-ийн өгөгдлийг нейронавигаци, стереотактик системтэй интеграцчилж, тархи, нуруу нугасны гүний болон төвөгтэй байрлалтай хавдрын биопси, мэс засал, туяа эмчилгээний аюулгүй байдал, үр дүнг дээшлүүлэх;
- Мэдрэлийн мэс заслын эмч, бусад мэргэжилтнийг олон улсын түвшинд бэлтгэх;
- “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ын “А-1” заалтыг хасах нөхцөлийг бүрдүүлэх.

Төсөл хэрэгжих хугацаа: 3 жил

Төсөл хэрэгжих байршил: Хавдар судлалын үндэсний төв

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин:

- 1.2. Хорт хавдраар нас барсан 100,000 хүнд ноогдох тоог 2030 он гэхэд 8.0 болгон бууруулах зорилт.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

•2.3.1.3."Эрүүл шүд", "Хорт хавдраас сэргийлэх, хянах", зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл:

•2.2.1.Хүн амд зонхилон тохиолдож байгаа зүрх судас, хавдрын өвчлөлийг эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Төслийн санхүүжилт, төсөвт өртөг

Төслийн хүрээнд худалдан авах тоног төхөөрөмж:

№	Тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоо	Нийт (Евро)
1	Neurosurgical microscope KINEVO 900 Carl Zeiss Advancing Surgical Certainty/Мэдрэлийн мэс заслын микроскопи KINEVO 900 Carl Zeiss (BrainLab навигаци системтэй 3 хэмжээстээр холбогдон ажиллах, мэс заслын үеийн явцыг буюу хавдрын үлдэц байгаа эсэхийг хянах-QEVO ECU, мэс заслын хүндрэлийг эрс бууруулах)	1	1,000,000.00
2	Neurosurgical 3D exoscory Aescular Aeos/Мэдрэлийн мэс заслын 3 хэмжээст экзоскопи Aescular Aeos мэс засалд зарцуулах хугацааг, мэс заслын дараах хүндрэлийг эрс бууруулах.	1	400,000.00
3	Loop X O-Arm Neurosurgical intraoperative cone beam CT BrainLab/Мэдрэлийн мэс заслын үеийн компьютер томографи BrainLab (BrainLab навигаци системтэй холбогдон тархи, нугасны 3 хэмжээст зураглалаар мэс заслын үеийн явцыг хянах, хүндрэлийг бууруулах давуу талтай)	1	900,000.00
4	Karl Storz нейроэндоскопийн 4K 3D дэлгэц дүрслэл хувиргагч мөн автомат камер баригч гар.	1	400,000.00
5	Intraoperative neurosurgical computer tomography Siemens Nexaris /Мэдрэлийн мэс заслын үеийн компьютер томографи/	1	1,000,000.00
6	Bone scalpel NEXUS/Гавал, гавлын суурийн яс болон нурууны мэс заслын үеийн ясны хутга NEXUS (тархи болон нугасны гэмтлээс хамгаалах)	1	500,000.00
7	BrainLab Cirq Robot system/BrainLab навигаци системтэй холбогдон тархи, нугасны гүний хавдар болон нуруу нугалмын мэс заслын нарийвчлалыг тодорхойлж хяналт хийж, мэс заслын хүндрэлээс сэргийлэх	1	350,000.00
8	Neurosurgical intraoperative 3D ultrasound of brain tumor and vessels BK5000/Тархи, нугасны хавдрын болон тархины судасны үеийн хэт авианы аппарат BK5000 (BrainLab навигаци системтэй 3 хэмжээстээр холбогдон хавдрын судасжилт болон үлдэц байгаа эсэхийг хянах)	1	200,000.00
9	Quanta System Opera Evo laser minimally invasive neurosurgery/Quanta систем мэдрэлийн мэс засал	1	300,000.00
10	Stereotactic frame Leksell biopsy and DBS for parkinson disease/Стереотактик эдийн шинжилгээ авах болон Паркинсон өвчний эмчилгээний төлөвлөлтийн толгойн хүрээ (программ тусгай лицензийн хамт)	1	500,000.00
11	Medtronic Pneumatic high speed Neuro Drill/Өндөр хурдны мэдрэлийн мэс заслын хийн даралтат өрөм	2	100,000.00
12	Maquet Carbon Neurosurgical table/Мэдрэлийн мэс заслын рентген ойлт хязгаарлагч ор	1	300,000.00
13	DORO, Skull Clamp Radiolucent/Рентген харагдахгүй толгой бэхлэгч ДОРО	2	200,000.00
14	Мэдрэлийн мэс заслын бичил багажийн иж бүрдэл	2	400,000.00
15	Loop 3.5X XenoSys, USA	3	15,000.00
16	Тархины эдийн дотоод даралт хэмжигч аппарат	3	75,000.00

17	Neurosurgical 3D C-Arm /Мэдрэлийн мэс заслын 3 хэмжээст зөөврийн рентген аппарат (BrainLab навигаци системтэй холбогдон тархи, нугасны гэмтлээс хамгаалах давуу талтай)	1	350,000.00
18	Neurosurgical Spine system Easy Go II/Spine TIP KARL STORZ/Мэдрэлийн мэс заслын нуруу нугасны эндоскопийн систем Easy Go II/Spine TIP KARL STORZ (нуруу нугасны мэс заслыг бага хөнөөлтөөр, өвчтөний амьдралын чанар сайжрах, мэс заслын үеийн явцыг хянах, хүндрэлийг бууруулах давуу талтай)	1	250,000.00
19	Тархины цахилгаан бичлэгийн оношилгооны аппарат	1	80,000.00
20	Захын мэдрэлийн мэдрэл булчингийн цахилгаан бичлэгийн оношилгооны аппарат	1	80,000.00
21	Рентген цацрагаас хамгаалах иж бүрдэл хэрэгсэл	10	30,000.00
22	Рентген цацрагаас хамгаалах тугалган хөдөлгөөнт хаалт	2	10,000.00
23	Мэдрэлийн мэс заслын сандал	1	20,000.00
24	Мэдрэлийн мэс заслын гар амраагч хөдөлгөөнт тавиур	1	3,000.00
25	Neuronavigation системийн төлөвлөлт хийх зориулалттай тусгай тоноглол бүхий суурин компьютер /Planning Station/	1	40,000.00
26	Мэдрэлийн мэс заслын төлөвлөлт хийх зориулалт бүхий хөдөлгөөнт компьютер /Microsoft үйлдлийн систем/	1	7,000.00
27	Сургалт /Гадаад сургалт/	1	190,000.00
28	Fully Installed Operation Theater /Мэдрэлийн мэс заслын зориулалтын иж бүрэн тоноглогдсон мэс заслын өрөө болон PET Scan тоног төхөөрөмжийн өрөөний иж бүрэн засвар	1	450,000.00
29	PET Scan тоног төхөөрөмж	1	650,000.00
30	Туяа эмчилгээний төлөвлөлтийн систем контурингийн ажлын компьютер, лицензийн хамт (Radiotherapy treatment planning system-1 with contouring workstation-3)	3	150,000.00
31	Алсын зайн холболт (remote DICOM connection)	1	50,000.00
32	Хөдөлгөөнгүй байлгах хэрэгслийн иж бүрдэл (Immobilization device set)	1	100,000.00
33	Хойд бүсийн дэд төвд туяа эмчилгээний бункер байгуулах	1	900,000.00
НИЙТ			10,000,000

Гурав. Төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр дараах үр дүн гарахаар хүлээгдэж байна:

- Мэдрэлийн мэс заслын нейронавигаци, стереотактик оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи нэвтэрсэн байна;
- Орчин үеийн өндөр нарийвчлалтай мэдрэлийн мэс заслын багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна;
- Хорт хавдрын эрт илрүүлэлт, үнэн зөв оношилгоо, үе шат тогтоолт PET-CT-д суурилан олон улсын стандартын түвшинд хүрнэ. MRI, CT-ээр тодорхой бус тохиолдолд хавдрын идэвхтэй эд, тархалт, метаболизмыг ялган оношлох, стереотактик мэс засал, туяа эмчилгээний нарийвчлал нэмэгдэж, хүндрэл, эрсдэл буурна;
- Монгол Улсын иргэд гадаад улсууд руу өндөр өртөгтэй хорт хавдрын эмчилгээний санхүүгийн дарамт буурна;
- “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ын “А-1” заалтыг хасах эрх зүйн орчин бүрдсэн байна.

---oOo---


**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР**

БОЛОН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХООРОНДЫН

**САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛЭЛЦЭЭР**



Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газрыг төлөөлж Холбооны Сангийн сайд болон Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд нар, цаашид "Гэрээлэгч талууд" гэх:

- Хоёр орны өнөөгийн найрсаг харилцааг цаашид улам өргөжүүлэн хөгжүүлэх,
- Хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхийг эрмэлзэн,
- Гэрээлэгч талууд 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах тухай Эрмэлзлийн захидлыг харгалзан,

дараах зүйлсийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

1.1. Гэрээлэгч талууд нь өөрсдийн орны хууль дүрэм, журам, баримталж буй бодлого болон олон улсад хүлээсэн үүргийн дагуу санхүүгийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, өргөжүүлэхээр чармайн ажиллана.

2 дугаар зүйл

2.1. Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Сангийн сайд Санхүүгийн хамтын ажиллагааг дэмжих, өргөжүүлэх зорилгоор Экспортын санхүүжилтийн системийн дагуу арилжааны банкуудаар дамжуулан Вена хот дахь Австрийн Контролбанк ХК (OeKB)-наас дахин санхүүжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх төслүүдэд зориулж урьдчилсан байдлаар санхүүжилтийн хэмжээг 65,000,000 (жаран таван сая) евро хүртэл байхаар тогтов.

3 дугаар зүйл

3.1. Австрийн хөнгөлөлттэй санхүүжилт нь нөхцөлт тусламжийн зээл хэлбэрээр хөнгөлөлттэй зээлийн хөнгөлөлтийн түвшний хамгийн доод шаардлагыг хангасан, урьдчилан-холигдсон зээлийн санхүүжилтийн хэлбэрээр олгогдоно.

3.2. Нөхцөлт тусламжийн зээлийн нөхцөл нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын "Албан ёсны дэмжлэг бүхий



экспортын зээлийн журам”, Олон улсын валютын сан (ОУВС)-гийн Өрийн хязгаарын бодлого зэрэг олон улсын баримт бичгийн аль хамааралтайг үндэслэн тогтоогдоно. Үүний дагуу нөхцөлт тусламжийн зээлийн хөнгөлөлтийн түвшин нь хамгийн багадаа 35% байна.

2027 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөх Австрийн Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн нөхцөлийг энэхүү Хэлэлцээрийн Хавсралт I-т хавсаргав.

3.3. Гэрээлэгч талууд энэхүү зээлийн нөхцөл болон шаардлага нь ЭЗХАХБ-аас тогтоодог улсын эрсдэлийн ангиллаас хамаарч өөрчлөгдөж болохыг тэмдэглэж байна.

4 дүгээр зүйл

4.1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх эрх бүхий төслүүдийг төсөл бүрээр үнэлэх бөгөөд "Хэлсинки"-гийн нөхцөлт тусламжийн журам болон улсын төсвийн хуваарилалтын шалгуур үзүүлэлтийн аль тохиромжтойг харгалзан тогтооно. Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх салбаруудын урьдчилсан жагсаалтыг Гэрээлэгч талууд тодорхойлж, Гэрээлэгч талууд энэхүү Хэлэлцээрийн Хавсралт III-т тусгав.

5 дугаар зүйл


5.1. Төслийн худалдан авах ажиллагааг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу явуулна.

6 дугаар зүйл

6.1. Австрийн Контрол банк (ОеКВ)-наас дахин санхүүжигдэх зээлийн гэрээний нөхцөлийг зээлдүүлэгч болох арилжааны банкууд болон зээлдэгч болох Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яамны хооронд тохирч шууд хэлэлцээ хийх замаар байгуулна.

7 дугаар зүйл

7.1. Энэхүү Хэлэлцээрт хамрагдан санхүүжигдэх төслүүдийн жагсаалтыг Монгол Улсын Сангийн яам болон Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Сангийн яам хооронд албан бичиг солилцох замаар харилцан тохиролцоно.



Санхүүжилтэд хамрагдах боломжтой төслүүдийн урьдчилсан жагсаалтыг Хэлэлцээрийн Хавсралт II-т тусгасан болно. Уг жагсаалт нь өөрчлөгдөх боломжтой бөгөөд шаардлагатай тохиолдолд Талууд албан бичиг солилцох замаар нэмэлт засвар оруулж болно.

Хэлэлцээрийн дагуу албан үйл ажиллагаа нь дэс дараалсан байдлаар явагдана. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хэлэлцэж байсан төслүүдийг мөн хамруулж болно.

8 дугаар зүйл

8.1. Хэлэлцээрийн хүрээнд олгож буй нөхцөлт тусламжийн зээлээр Австри Улсын гарал үүсэл бүхий бараа, үйлчилгээг худалдан авах бөгөөд үүнээс 50% хүртэлх бараа, үйлчилгээ нь Австри Улсын бус гарал үүсэлтэй байж болно.

9 дүгээр зүйл

9.1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээд бий болж буй бүх төлбөрийг эргэж буцалтгүйгээр, үл маргах замаар гүйцэлдүүлэхийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам үүгээр баталгаажуулан, энэхүү Хэлэлцээрээр баталгаажуулсан төлбөрөөс чөлөөлөгдөх аливаа эрхээсээ эргэж буцалтгүйгээр түдгэлзэв.

10 дугаар зүйл

10.1. Австрийн экспортын санхүүжилтийн системийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр худалдан авсан бараа, үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулах НӨАТ болон гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

10.2. Австрийн экспортын санхүүжилтийн системийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлийн төлбөрт үзүүлж буй татварын чөлөөлөлтийг 2003 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Бүгд Найрамдах Австри Улс болон Монгол Улсын хоорондын орлого, хөрөнгийн албан татварын тухай хэлэлцээр”-ийн дагуу зохицуулна.

11 дүгээр зүйл

11.1. Гэрээлэгч талууд энэхүү Хэлэлцээрийн явцыг үнэлж, шинэчлэлтийн асуудлыг хэлэлцэн гарч болзошгүй бусад асуудлаар Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам үүгээр баталгаажуулан, энэхүү Хэлэлцээрээр баталгаажуулсан төлбөрөөс чөлөөлөгдөх аливаа эрхээсээ эргэж буцалтгүйгээр түдгэлзэв.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ
САНГИЙН ЯАМ
ДЭМЖЛЭГТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН
ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВСАН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ
НЬ МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭЭР
НОГДУУЛАХ НӨАТ БОЛОН ГААЛИЙН ТАТВАРААС
ЧӨЛӨӨЛӨГДӨНӨ.

Гарын үсэг /Signature/ *Морца*

2026 оны 5 сарын 11 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

12 дугаар зүйл

12.1. Хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг үнэлэх зорилгоор энэхүү Хэлэлцээрийн хүрээнд болон холбогдох төслүүдийн тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газар төслүүдийн хэрэгжилтийн явцыг үнэлэх, хянах, аудит хийхэд шаардлагатай бүхий л баримт бичгээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

13 дугаар зүйл

13.1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах ба/эсхүл хэрэгжүүлэхэд Гэрээлэгч талуудын хооронд үүссэн аливаа маргааныг найрсгаар дипломат шугамаар шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл

14.1. Хэлэлцээр нь Гэрээлэгч талууд дотоодынхоо хууль, тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа харилцан мэдэгдсэн сарын дараагийн сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

14.2. Энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр хугацаа хоёр (2) жил байх бөгөөд Гэрээлэгч талуудын нэг нь аль ч үед гэрээг дуусгавар болгоогүй бол ЭЗХАХБ-аас баталсан “Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн журам” зэрэг олон улсын үүргүүдийн хүрээнд хоёр тал харилцан зөвшөөрсний үндсэн дээр цааш хоёр жилийн хугацаагаар гэрээний хугацааг шинэчилж болно.

14.3. Хэлэлцээрийг дуусгавар болгохоор санал болгож буй өдрөөс зургаа (6) сарын өмнө бичгээр мэдэгдэнэ. Хэлэлцээрийг цуцлах нь энэхүү Хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй үйл ажиллагаатай холбоотой Гэрээлэгч талуудын үүрэгт нөлөөлөхгүй.

14.4. Энэхүү Хэлэлцээрийг цуцлах эсхүл хугацаа дуусахаас үл хамаарч энэхүү Хэлэлцээрийн хүрээнд тодорхойлж, байгуулсан арилжааны гэрээ болон зээлийн хэлэлцээрийн заавал биелүүлэх шинж чанар хэвээр байна. Эдгээр гэрээ болон хэлэлцээрүүд нь өөрсдийн нөхцөл, болзлын дагуу хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон заалтууд мөн төслүүдийн хүрээнд хүчин төгөлдөр хэвээр байна.



Хэлэлцээрийг өдөр болон өдөр англи
хэлээр 2 хувь байгуулсан.

Бүгд Найрамдах Австри
Улсын Засгийн газрыг төлөөлж
Холбооны Сангийн сайд

Монгол Улсын Засгийн
газрыг төлөөлж Сангийн сайд




Хавсралт I

2027 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөх Австрийн Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн нөхцөл.

Урьдчилан-холигдсон Зээл

- 100 % хөнгөлөлттэй зээл
- Эргэн төлөгдөх нөхцөл: 19 жил (4 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө, хагас жил тутмын 30 удаагийн төлбөрөөр эргэн төлөгдөнө)
- Зээлийн хүү: Жилийн 1.00 %
- Баталгааны шимтгэл: Жилийн 0.90 %
- Хөнгөлөлтийн түвшин: ЭЗХАХБ-ын дүрмийн дагуу 42.81%


Энэхүү зээлийн нөхцөл болон шаардлага нь ЭЗХАХБ-аас тогтоодог улсын эрсдэлийн ангиллаас хамаарч өөрчлөгдөж болно.



Хавсралт II

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалт


№	Төслийн нэр	Төслийн урьдчилсан дүн (сая евро)
1	Хорт хавдрын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл	10.0
2	Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	7.5
3	Монгол Улсад эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл	8.0
4	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	10.0
5	Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн гуравдугаар үе шатны төсөл	10.0
6	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ба хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах дараагийн шатны төсөл	9.5
7	Дуурь, бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл	10.0
Нийт дүн		65.0



Хавсралт III

Санхүүгийн үр ашиггүй төслүүдтэй холбоотой “Хэлсинки”-гийн нөхцөлт тусламжийн журмын туршлагыг үндэслэн салбаруудыг хөнгөлөлттэй санхүүжилтэд хамруулах боломжтой гэж үзнэ:

- Эрүүл мэндийн салбар түүнд эмнэлэг болон эмнэлгийн тоног төхөөрөмжийг хамруулан
- Нийгмийн дэд бүтэц
- Хотын ус хангамж болон ариутгах байгууламж
- Хог хаягдал болон бохир ус
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал болон төмөр зам
- Боловсрол болон мэргэжлийн сургалт
- Иргэний хамгаалалт
- Хөдөө аж ахуй
- Бусад дэд бүтэц.



AGREEMENT

BETWEEN

THE GOVERNMENT

OF THE REPUBLIC OF AUSTRIA

AND

THE GOVERNMENT OF MONGOLIA

ON

FINANCIAL CO-OPERATION

The Government of the Republic of Austria, represented by the Federal Minister of Finance, and the Government of Mongolia, represented by the Minister of Finance, hereunder called the "Contracting Parties",

- desiring to promote further the close and friendly relations existing between the two countries,

- desiring to extend and deepen the co-operation,

- taking account of the Letter of Intent on Financial Co-Operation signed by both Contracting Parties on May 26th 2025,

have agreed as follows:

Article 1

1.1. The Contracting Parties will endeavour, within the framework of their respective existing laws, regulations and policies as well as their international obligations to promote and expand financial co-operation.

Article 2

2.1. For the purpose of promoting and expanding financial co-operation, the Austrian Federal Minister of Finance is prepared to support the provision of concessional credits, refinanced by Oesterreichische Kontrollbank Aktiengesellschaft (OeKB), Vienna, through commercial banks under the Export Financing Scheme. An indicative financial framework amount of up to EUR 65.000.000 - (Euro sixtyfive million) is envisaged for the financing of projects under the present Agreement.

Article 3

3.1. Austrian concessional financing is principally offered as tied aid financing in the form of pre-mixed credits subject to a minimum concessionality requirement.

3.2. The terms and conditions of the tied aid credits are set in accordance with international obligations such as the "Arrangement on Officially Supported Export Credits" under the auspices of the OECD and the Debt Limits Framework of the

IMF, as applicable. Accordingly, the concessionality level will be at least 35 % for tied aid credits.

The terms and conditions under the Austrian Soft Loan Scheme valid until January 14th 2027 are attached as Annex I of the present Agreement.

3.3. The Contracting Parties note that the terms and conditions may be subject to change due to changes in the OECD country risk classification.

Article 4

4.1. The eligibility of projects to be financed under the present Agreement, will be appraised on a case by case basis, taking into consideration the ex-ante guidance/experiences gained under the "Helsinki" tied aid disciplines and national requirements and criteria, as applicable. An indicative List of eligible project sectors is attached as Annex III of the present Agreement.

Article 5

5.1. Project procurement is to be made in accordance with the Mongolian laws and regulations.

Article 6

6.1. Loan agreements, refinanced by OeKB are negotiated and concluded directly between commercial banks as lenders and the Government of Mongolia represented by the Ministry of Finance as borrower.

Article 7

7.1. Projects to be financed and included under the present Agreement shall be agreed upon through exchange of letters between the Ministry of Finance of Mongolia and the Federal Ministry of Finance of the Republic of Austria. An indicative list of possible projects for financing is attached as Annex II of the present Agreement. This list is subject to change and can where necessary be updated by the Contracting Parties through exchange of letters.

The formal inclusion under the present Agreement shall be effected in a consecutive manner. Projects under negotiation before the entry into force of the present Agreement may also be included.

Article 8

8.1. Tied aid loans, extended under the present Agreement, are to be utilized for the purchase of Austrian goods and services, which may include up to 50 % goods and services originating outside Austria.

Article 9

9.1. The Government of Mongolia represented by the Ministry of Finance hereby irrevocably and unconditionally guarantees the fulfilment of all payments resulting from the present Agreement and irrevocably waives any claim to immunity it might be entitled to in respect of payments guaranteed under the present Agreement.

Article 10

10.1. Goods and services, procured under concessional loans officially supported by the Austrian export financing system, shall be exempt from the value added taxes and customs tax within the territory of Mongolia.

10.2. Tax exemptions to be applied to payments by the borrower under concessional loans officially supported by the Austrian export financing system shall be regulated by the "Convention between the Republic of Austria and Mongolia with respect to taxes on income and on capital" dated July 3, 2003.

Article 11

11.1. The Contracting Parties shall review the progress of the present Agreement, discuss updates and agree on any other matters arising on an annual basis or whenever deemed necessary.

Article 12

12.1. In order to evaluate the use of the concessional loans, under the present Agreement and the sustainability of the corresponding projects, the Government of

Mongolia will facilitate the provision of all necessary documentation for evaluation, auditing and monitoring of the projects.

Article 13

13.1. Any disputes between the Contracting Parties concerning the interpretation and/or implementation of the present Agreement shall be settled amicably through diplomatic channels.

Article 14

14.1. The present Agreement will enter into force on the first day of the month following the month in which the Contracting Parties have notified each other of the fulfilment of all procedures necessary in their respective country.

14.2. The present Agreement shall remain in force for a period of two (2) years and may be renewed thereafter upon mutual consent for further two-year periods unless terminated at any time by either Contracting Party, all in accordance with international obligations such as the "Arrangement on Officially Supported Export Credits" under the auspices of the OECD.

14.3. The termination shall be effected by six (6) months written notification in advance of the proposed termination date. The termination shall not affect the obligations of the Contracting Parties already entered into pursuant to the present Agreement.

14.4. The termination or elapsing of this Agreement shall not affect the binding nature of the commercial contracts and the loan agreements of projects which have been identified and initiated under this Agreement. These contracts and agreements shall continue to be in force according to their own terms and conditions. The provisions agreed upon in the present Agreement shall also continue to apply to any such projects.

Done at on and at on
in two originals, both in English language.

For the Government of the
Republic of Austria
represented by the
Federal Minister of Finance

For the Government of
Mongolia
represented by the
Minister of Finance

Annex I

Terms and conditions under the Austrian Soft Loan Scheme valid until January 14th 2027.

Pre-Mixed Credit:

- 100 % Soft Loan
- Repayment Term: 19 years (4 years grace period, repayment in 30 half yearly instalments)
- Interest Rate: 1.00 % p.a.
- Guarantee Charge: 0.90 % p.a.
- Concessionality Level: 42.81 % according to OECD rules

These terms and conditions may be subject to change due to reclassification in the OECD country risk classification.

Annex II

Indicative list of Projects to be financed under this Agreement

№	Project name	Indicative project amount (million euro)
1	Modernization of oncological surgical equipment and expansion of related healthcare services	10.0
2	Enhancement of the quality, accessibility, facilities, and equipment of trauma and orthopedic services	7.5
3	Project for the reduction of maternal, child, and neonatal mortality in Mongolia	8.0
4	Improving the quality and accessibility of healthcare services at the First National Central Hospital	10.0
5	Phase III of the project to modernize equipment at the Central Military Hospital	10.0
6	Next-phase project to upgrade and install medical equipment and devices, and to strengthen human resource capacity at the General Hospital for Special State Servants and healthcare institutions in the western and eastern border regions	9.5
7	Modernization of stage and sound equipment of the Academic Theatre of Opera and Ballet building	10.0
Total		65.0

Annex III

Based on experiences under the “Helsinki” tied aid disciplines with respect to financially non-viable projects, the following sectors can in principle be considered for concessional financing:

- Health sector including hospital and medical equipment
- Social infrastructure
- Municipal water and sanitation
- Waste and sewage
- Traffic safety and railways
- Education and vocational training
- Civil protection
- Agriculture
- Other infrastructure.

**“ХОРТ ХАВДРЫН НЕЙРОНАВИГАЦ, СТЕРЕОТАКТИК ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ
УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН
ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсад оношлогдож буй хорт хавдрын 70 гаруй хувь нь хожуу шатандаа илэрч, тархи, нугасны гүний хавдрын олон тохиолдолд дотоодын оношилгоо, эмчилгээний боломж хязгаарлагдмал байна /орчин үеийн нейронавигаци, стереотактик эмчилгээний төв байгуулах нэн шаардлагатай/. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан статистик үзүүлэлтээр эмчлэх боломжгүй өвчний жагсаалтын дагуу сүүлийн 9 жилийн хугацаанд төв мэдрэлийн системийн хавдрын тохиолдол эрс өссөн статистик гарсан байна. Ялангуяа тархины гүний төвөгтэй байрлалтай хавдрын мэс засал, эмчилгээ, мэс заслын дараах хүндрэл болон нас баралт нь анхаарал татах асуудал болсоор байна. Иймд энэхүү чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчнийг сургалтад хамруулан чадавхжуулж, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдээр хангагдах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/273 дугаар тоот тушаалаар Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон “Тархи нугасны гүний, төвөгтэй байрлалтай, нэвчсэн, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал, эмчилгээ” А-1 заалтыг хасан, дотооддоо үе шаттайгаар шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Монгол Улсад тархи, нуруу нугасны хавдрын оношилгоо нь ихэвчлэн MRI, CT дүрслэлд тулгуурлаж байгаа боловч:

- Хавдрын идэвхтэй (амьд) эдийг сорвижилт, некрозоос ялгах боломж хязгаарлагдмал;
- Дахилт эсэх, эмчилгээний үр дүнг эрт үнэлэх боломж хангалтгүй;
- Биопси, мэс заслын зорилтот хэсгийг оновчтой тодорхойлох нарийвчлал дутмаг;
- Стереотактик туяа болон мэс заслын эмчилгээний төлөвлөлтөд функциональ мэдээлэл дутагдалтай байна.

Эдгээр шалтгаанаар тархины гүний, төвөгтэй байрлалтай хавдарт онош хоцрох, эмчилгээний үр дүн буурах, хүндрэл болон нас баралт нэмэгдэх бодит эрсдэл үүсэж байна. PET-CT нь анатомийн бус метаболизм, эсийн идэвхийг харуулдаг дэвшилтэт оношилгооны арга бөгөөд тархи, нугасны хавдрын үед дараах давуу талуудыг бий болгоно:

- Оношилгооны нарийвчлал;
- Хавдрын идэвхтэй хэсгийг өндөр нарийвчлалтай тодорхойлох;
- MRI-д тодорхой бус харагдах low-grade vs high-grade хавдрыг ялгах;
- Radiation necrosis vs tumor recurrence-ийг ялган оношлох.

Хүснэгт 1. "Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтын дагуу Эрүүл мэндийн статистикаар бүртгэгдсэн өвчнийг түүвэрлэн харьцуулсан үзүүлэлт", 2014 он, 2023 он

ҮЗҮҮЛЭЛТ	2014	2023
Тархины өмөн	103	509
Тархины, байршил тодорхойгүй	43	84
Нугасны	0	12
Төв мэдрэлийн тогтолцооны, байршил тодорхойгүй	1	4
Тархи-нугасны бүрхүүлийн хоргүй хавдар	47	331
Тархи ба төв мэдрэлийн тогтолцооны бусад хэсгийн хоргүй хавдар	290	1010
Тархины майхнаас дээших хэсгийн	84	2401
Төв мэдрэлийн тогтолцооны бусад тодорхой хэсгийн	1	64
Тархины, тодорхойгүй	1	1

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2023 оны статистик тоон үзүүлэлтээс харахад тархи, нугасны хортой хавдрын тохиолдол 100,000 хүн ам тутамд 10.4 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс эр-3.8, эм-6.6 тус тус байна. Монгол Улсын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүн амын тоотой харьцуулахад жилд дунджаар 368.6 тохиолдол бүртгэгдэж байна.

Үндэслэл

Хавдрын өвчлөлийг бууруулах нь улс орны хүний хөгжлийн индекс, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг тодорхойлох суурь үзүүлэлтүүдийн нэг юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үзэж буйгаар хорт хавдрыг эрт илрүүлж, зохистой удирдлага, эмчилгээ хийснээр амьдралын чанар, дундаж наслалтыг мэдэгдэхүйц сайжруулах боломжтой гэж үздэг.

Анагаах ухааны үүднээс авч үзвэл хорт хавдрын эрт оношилгоо нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах гэсэн тусламжийн бүх үе шатыг хамарсан цогц тогтолцооны салшгүй хэсэг юм. Ялангуяа тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудын нарийн мэс засал эмчилгээ нь эрүүл мэндийн тусламжийн гуравдагч шатны өндөр технологи, өндөр мэргэшил шаардсан үйлчилгээ бөгөөд улс орны эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Ихэнх орнуудад хорт хавдрын үеийн стандарт үзлэгт компьютер томографи, соронзон үелзүүрт томографи шинжилгээ, зарим генетикийн скринингийг заавал хамруулдаг бөгөөд онош батлагдсан тохиолдолд олон мэргэжилтний хамтарсан үзлэг, эмнэлзүйн хэлэлцүүлэг хийн, мэс заслын бэлтгэлийг урьдчилан төлөвлөдөг. Энэ нь хүний нөөцийг тогтвортой хөгжүүлэх, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийг оновчтой ашиглах, эмчилгээний үр дүнг сайжруулах давуу талтай байдаг. Хорт хавдрыг эрт оношлох, нарийн мэс заслыг хөгжүүлэх бодлого нь зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал бус, нийгэм, эдийн засгийн урт хугацааны хөрөнгө оруулалт болох нь нотлогдсон байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хорт хавдрын чиглэлээр авах арга хэмжээний хувьд тодорхой ахиц гарч байгаа хэдий ч тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудын эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний нарийн мэс заслын тусламж, үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдал зэрэг нь хангалтгүй хэвээр байна.

Тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудын нарийн мэс засал эмчилгээний хувьд төвлөрсөн хэдхэн эмнэлэгт хязгаарлагдан хэрэгжиж, зарим тохиолдолд гадаад улсад эмчлүүлэх шаардлага үүсэж, гэр бүл болон улсын хэмжээнд санхүүгийн дарамт учруулж байна. Үүнээс гадна тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудын талаарх үндэсний хэмжээний тандалт, мэдээллийн сан бүрэн төлөвшөөгүй байгаа нь бодлого, төлөвлөлтийг нотолгоонд суурилан хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Иймд цаашид тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудыг эрт үед оношлон илрүүлэх, хавдартай өвчтөний амьдралын чанарыг нэмэгдүүлэх, эмчилгээний тасралтгүй, чанартай тогтолцоог бүрдүүлэх, нотолгоонд суурилсан тандалт, судалгааг сайжруулах шаардлага буй болоод байна.

Эрүүл мэндийн бодлогын онолоор тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудыг эрт оношлох, оношилгоо, эмчилгээний нарийн мэс заслын тусламж, үйлчилгээг сайжруулах нь дараах үндсэн зарчмуудад тулгуурлана:

- **Урьдчилан сэргийлэх ба эрт илрүүлэх зарчим** – хавдрыг хожуу шатанд эмчлэхээс илүүтэй эрт илрүүлж, үр дүнтэй удирдах;
- **Тэгш хүртээмжийн зарчим** – хот, хөдөөгийн ялгааг бууруулж, иргэн бүр чанартай тусламж авах боломжийг хангах;
- **Нотолгоонд суурилсан бодлого** – тандалт, судалгааны мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;
- **Тогтвортой хөгжлийн зарчим** – чадварлаг хүний нөөцөд чиглэсэн урт хугацааны хөрөнгө оруулалт хийх.

Эдгээрийг шийдвэрлэх гол бодлогын шийдлүүд нь:

1. Эрт оношилгоог өргөжүүлэх:

- Тархи, нугасны хортой болон хоргүй хавдрын үеийн стандарт үзлэг, шинжилгээг сайжруулах;
- Тархи, нугасны хортой болон хоргүй хавдрын үеийн компьютер томографи, соронзон үелзүүрт томографи, тархины судасны ангиографийн шинжилгээ, генетикийн оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлэх.

2. Тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудын нарийн мэс заслын чадавхыг бэхжүүлэх:

- Төвлөрсөн лавлагаа шатлалын эмнэлгийг орчин үеийн, дэвшилтэт тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангах;
- Гадаад, дотоод сургалт, мэргэшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх.

3. Эмчилгээний уялдаа холбоог сайжруулах:

- Тархи, нугасны хортой болон хоргүй хавдрын анх оношлогдсон үеэс эхлэн эмчлэх, сэргээн засах төлөвлөгөөний нэгтгэсэн тогтолцоо бүрдүүлэх;
- Олон мэргэжилтний хамтарсан үзлэг, эмнэлзүйн хэлэлцүүлэг хийх.

4. Тандалт, мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх:

- Тархи, нугасны хортой болон хоргүй хавдруудын үндэсний бүртгэл бий болгох;
- Судалгаа, дүн шинжилгээнд суурилсан бодлого боловсруулах.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Монгол Улсад тархи, нугасны гүний, төвөгтэй байрлалтай хавдрын мэс заслын тусламж, үйлчилгээ сүүлийн жилүүдэд хөгжиж, тодорхой төрлийн мэс заслыг дотооддоо хийх боломж бүрдэж эхэлсэн боловч нэвчсэн болон өндөр эрсдэлтэй хавдрын иж бүрэн эмчилгээ (мэс засал, туяа, эмийн эмчилгээ)-ний чадамж хангалтгүй хэвээр байна. Үүний улмаас мэдрэлийн болон хавдрын шалтгаант өвчтөнүүдийн тодорхой хувь гадаад улс оронд эмчлүүлэх шаардлагатай хэвээр байгаа нь валютын урсгал алдагдах, эмчилгээний хүртээмж буурах, нас баралт нэмэгдэх шалтгаан болж байна.

Жилд 130 орчим тохиолдол бүртгэгддэг бөгөөд үүний 20% (26 хүн) гадаадад эмчлүүлдэг, 80% (104 хүн) нь дотоодод эмчлүүлэх боломжгүй байна. Жилд ойролцоогоор 1.6 тэрбум төгрөгөөр өвчтөнүүд гадаад эмчлүүлж байна. Хорт хавдрын нейронавигаци, стретактик оношилгоо, эмчилгээний төв байгуулагдсанаар тохиолдлын 70% нь дотооддоо эмчлүүлэх боломжтой болох бөгөөд одоогийн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол дахь өртгийн жингээр үзвэл уг тусламж, үйлчилгээний өртөг 4,532,657 төгрөг байхаар байна.

Дотоод орлого жилд:


91 тохиолдол х 4,532,657 төгрөг = 412,471,787 төгрөг

Хүснэгт 2. Өвчний тохиолдлуудын нийт зардал болон даатгалын зардал.

Тохиолдол	Гарсан	Онош	Ү.код	Даатгал	Зардал
A	11 сар	c71.8	86.2	1,182,000	987,886
B	8 сар	d33.0	01.59	4,533,000	1,496,843
D	5 сар	d44.7	01.28	239,000	3,736,244
E	10 сар	d33.1	01.59	4,533,000	7,761,204
F	10 сар	d33.3	01.59	4,533,000	5,018,351
H	10 сар	d32.0	01.59	4,533,000	4,721,976
G	10 сар	d33.2	01.59	4,533,000	2,560,420
K	6 сар	d33.3	01.59	239,000	3,078,564
L	9 сар	d32.0	01.59	4,533,000	6,934,522
M	11 сар	d32.0	01.59	4,533,000	3,933,024
Нийт				45,330,000	40,229,034.0
Дундаж				4,533,000	4,022,903.4

Жич: Төв байгуулах төслийн саналд оруулсан нийт 33 нэр төрлийн тоног төхөөрөмж ашиглалтад орж, тусламж, үйлчилгээг үзүүлж эхэлснээр өртгийг дахин тооцоолж өртгийн жин болон тусламж, үйлчилгээний өртөг нэмэгдэх боломжтой. Дээрх өртгийн тооцоолол өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан тооцоолсон.

График 1. Эмнэлгийн дотоод орлогыг төслийн өмнөх болон дараах байдлаар хийсэн харьцуулалт.



Жилийн цэвэр үр ашиг

1.648 тэрбум ₮ /гадаад эмчилгээний зардал/ - 412.7 сая ₮ = 1.2 тэрбум төгрөг

Нийгмийн бодит үр өгөөж

Тохиолдлын 80% буюу 104 нь цогц эмчилгээ авч чаддаггүй.

Таамаглал

- 1 хүний жилийн дундаж орлого: 15 сая
- Хөдөлмөрийн чадвар алдалт: 70-100%
- Амжилттай эмчлэгдвэл чанартай амьдрах хугацаа: 5-10 жил

1 хүний алдагдсан эдийн засгийн боломж 15 сая x 10 жил = 150 сая / 70% амжилттай эмчлэгдвэл/

Хүснэгт 3. Төслийн жилийн нийгмийн өгөөжийн тооцоолол.

Үзүүлэлт	Тоо
Цогц эмчилгээ авч чадаагүй амьдралын болон хөдөлмөрийн чадвар алдагдсан хүн	104 хүн
1 хүний алдагдсан эдийн засгийн боломж	150 сая
Нийт алдагдал	15.6 тэрбум
Амьдралын болон хөдөлмөрийн чадвар сайжрах боломжтой хүн	73 хүн
Нийгмийн жилийн өгөөж	10.9 тэрбум

Хүснэгт 4. Төслийн нийт өгөөжийн тооцоолол.

Үзүүлэлт	Дүн
Жилийн цэвэр үр ашиг	1.2 тэрбум
Нийгмийн жилийн өгөөж	10.9 тэрбум
Нийт өгөөж	12.1 тэрбум

“ГЭМТЭЛ СОГОГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Гэмтэл согог судлалын үндэсний төв (цаашид “ГССҮТ” гэх)-ийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээг сайжруулах орчин үеийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Дүрс оношилгооны тоног төхөөрөмжийг шинэчлэх:

Орчин үеийн өндөр нарийвчлалтай тоног төхөөрөмж нэвтрүүлснээр оношилгооны чанар сайжирч, эмчилгээний үр дүн дээшилснээр өвчтөний эдгэрэлт, нөхөн сэргээлтийн хугацаа богиносно. Цаашлаад тоног төхөөрөмжийн хурд, ажиллагаа сайжирснаар илүү олон өвчтөнд түргэн, шуурхай үйлчилж, эмнэлгийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.

- Эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжийг шинэчлэх:

Эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжийг шинэчилснээр өвчтөний амь насыг аврах чадвар нэмэгдэхийн зэрэгцээ эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжирна. Оношилгоо, хяналтын үр дүн сайжирч, хүнд өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэхийн сацуу нас баралтын түвшин буурна.

- Мэс заслын тоног төхөөрөмжийг шинэчлэх:

Мэс заслын тоног төхөөрөмжийг шинэчлэн хүртээмжийг нэмэгдүүлснээр тусламж, үйлчилгээг олон улсын стандартын дагуу түргэн шуурхай, үр дүнтэй үзүүлж, мэс заслын дараах хүндрэлийг 30 хүртэл хувиар бууруулна.

- Гэмтлийн дараах сэргээн засах эмчилгээг төрөлжүүлж, сайжруулах:

Гэмтлийн дараах болон мэс заслын дараах сэргээн засах эмчилгээний төрөл, хүртээмжийг сайжруулснаар гэмтлийн дараах үйл ажиллагааны сэргэлт сайжирч, гэмтлийн дараах хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин буурна.

- Эмч, мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх:

Тоног төхөөрөмж ашиглалт, халдвар хяналтын сургалт, Мэс заслын протокол хэрэгжүүлэх дадлага сургалт явуулах.

Төслийн хэрэгжих хугацаа: 3 жил

Төслийн байршил: Гэмтэл согог судлалын үндэсний төв

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.

- 2.2.13.Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

- 2.2.18.Иргэд эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 2.2.28.Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

- 2.3.2.8.Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаанд цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал:

- 3.4.1.10.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоонд олон улсын стандартыг мөрдүүлж, оношилгоо, эмчилгээний олон улсын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.

Хоёр. Төслийн санхүүжилт, төсөвт өртөг

Төслийн хүрээнд худалдан авах тоног төхөөрөмж:

Дугаар	Нэрс	Нэгж үнэ евро	Тоо ширхэг	Нийт үнэ
ДҮРС ОНОШИЛГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ				
1	Ясны сийрэгжилтийг хэмжих аппарата (Bone densitometer DXA)	230,000.00	1.00	230,000.00
2	Суурин дижитал рентген аппарат харалттай	200,000.00	4.00	800,000.00
3	Суурин дижитал хэт авиан аппарат	55,000.00	3.00	165,000.00
4	Зөөврийн дижитал хэт авиан аппарат / Portable Ultrasound/	24,500.00	2.00	49,000.00
5	Зөөврийн тархины цахилгаан бичлэгийн 32 сувагтай аппарат	37,009.11	2.00	74,018.22
6	Дижитал C-Arm	173,000.00	8.00	1,384,000.00
7	Нярайн ташааны хэт авиан оношилгооны ор	7,552.88	2.00	15,105.76
	Дэд үнэ		22.00	2,717,123.98
ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ				
8	Амьсгалын аппарат /Ventilator/	36,000.00	10.00	360,000.00
9	Зөөврийн амьсгалын аппарат (MRI шинжилгээнд ашиглах боломжтой)	46,000.00	2.00	92,000.00
10	Эрчимт эмчилгээний функциональ ор	12,000.00	20.00	240,000.00
11	Зүрхний бичлэгийн аппарат /ECG Machine/	12,700.00	2.00	25,400.00
12	Шингэн соруулах аппарат /отсос/- Suction machine with Catheters	4,531.73	10.00	45,317.28
13	Зүрхний ажиллагаа дэмжигч /дифебрилятор/	4,000.00	20.00	80,000.00
14	Тариурын автомат шахуурга /Intravenous injection Pump/	4,078.55	10.00	40,785.55

15	Гавлын дотоод даралт хэмжигч монитор систем (ICP monitor system)	30,000.00	1.00	30,000.00
	Дэд үнэ		75.00	913,502.82
МЭС ЗАСЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ				
16	Жигут /Автомат чангалуур/-Automatic tourniquet surgical system	2,500.00	20.00	50,000.00
17	Унтуулгын аппарат	70,000.00	10.00	700,000.00
18	Мэс заслын ширээ	1,000.00	20.00	20,000.00
19	Цахилгаан хөрөө, дрилл иж бүрдэл /Milling Drill for Spine Surgery / Multi Function MicRo Power Tools/	12,000.00	40.00	480,000.00
20	Микро мэс заслын хэрэгсэл	12,200.00	9.00	109,800.00
21	Дурангийн мэс заслын иж бүрэн аппарат дурангийн /ком/	150,000.00	1.00	150,000.00
22	Мэс заслын ком багаж	30,000.00	20.00	600,000.00
23	Дерматом /газ / Zimmer air dermatome	15,000.00	10.00	150,000.00
24	Дерматом баттерей /Humeca/	13,000.00	10.00	130,000.00
25	Шархны сөрөг даралтын аппарат	3,000.00	20.00	60,000.00
26	Мэс заслын микроскоп	468,000.00	1.00	468,000.00
	Дэд үнэ		161.00	2,917,800.00
СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ				
27	Шарлагын аппарат /Hiper 500/	21,000.00	2.00	42,000.00
28	Бэхэлгээтэй алхуулагч төхөөрөмж	15,000.00	4.00	60,000.00
29	Сэргээн засахын автомат дасгалын ор	3,500.00	5.00	17,500.00
30	Үений хөдөлгөөн сайжруулах СРМ төхөөрөмж /elbow, knee, ankle CPM machine/	2,900.00	10.00	29,000.00
31	Лазер шарлагын аппарат /fractional CO2 laser equipment/	2,700.00	2.00	5,400.00
32	Shockwave цохилтот долгион эмчилгээ	50,000.00	2.00	100,000.00
33	Гүний осциллади (Deep isillation)	20,000.00	2.00	40,000.00
34	Хөргөх хүйтэн эмчилгээний аппарат (Cryolight& cryotherapy)	20,000.00	4.00	80,000.00
35	Pulsed magnetic therapy /Qs/	12,000.00	3.00	36,000.00
36	M Hi all therrain /MLS/ laser therapy	21,000.00	2.00	42,000.00
37	Anti gravity Treadmail	45,400.00	2.00	90,800.00
38	Электромиограмм аппарат	50,000.00	2.00	100,000.00
	Дэд үнэ		42.00	642,700.00
СУРГАЛТ				
39	Гадаад сургалт	308,873.20		308,873.20
НИЙТ				7,500,000.00

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Энэхүү төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд гарахаар хүлээгдэж байна:

- Оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламж, мэс засал, эрчимт эмчилгээ зэрэг тусламж, үйлчилгээг олон улсын стандартын дагуу түргэн шуурхай, үр дүнтэй үзүүлж, мэс заслын дараах хүндрэлийг 30 хүртэл хувиар бууруулна;

- Өндөр хүчин чадалтай дүрс оношилгооны төхөөрөмжүүд, мэс заслын тоноглол, эрчимт эмчилгээний болон тоног төхөөрөмж суурилуулснаар оношилгоо, эмчилгээний чанар сайжирна;

- Түргэн шуурхай, онош зөрөхгүй тусламжийн хүрээнд хүнд өвчтөний амь насыг аврах боломж нэмэгдэнэ;

- Өвчтөн шилжүүлэх шаардлага буурна. Тус эмнэлэг дотооддоо нарийн оношилгоо, эмчилгээг бүрэн гүйцэтгэх боломжтой болж, иргэдийн гадаад орон руу явах оношилгоо, эмчилгээний зардал буурч, өрхийн болон улс орны эдийн засагт зэрэг нөлөө үзүүлнэ;

- Эмч, мэргэжилтнүүдийн ур чадвар дээшилнэ;

- Гэмтлийн дараах сэргээн засах эмчилгээний чанар, хүртээмж сайжирч, үйл ажиллагааны сэргэлт хурдасна.

---oOo---

**“ГЭМТЭЛ СОГОГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР
ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын хэмжээнд 2025 онд 232,315 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 4.4 хувиар өсөж, хамгийн их тохиолдолтой жил болсон. Манай улсын 100,000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 6766.4 байна. 2025 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн 83.8% нь нийслэлд, 16.2% нь орон нутагт бүртгэгдсэн бөгөөд 100,000 хүнд ногдох тохиолдлын түвшнээр авч үзэхэд нийслэлд 11,617, орон нутагт 2,141 байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төв (цаашид “ГССҮТ” гэх)-д 2025 онд нийт 15,155 мэс засал буюу хэвтэн эмчлүүлэгчдийн 70.7% хувьд мэс засал эмчилгээ хийгдсэн ба 2024 оноос 5.2%-иар буурч, 2020 оноос 44.5%-иар нэмэгдсэн байна.

Тус төвд 2025 онд 99,338 сэргээн засах эмчилгээ хийлгэсэн ба өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 30.8%-аар, 5 жилийн дундажтай харьцуулахад 79.8%-аар тус тус нэмэгдсэн байна. Монгол Улсад гэмтэл, ослын шалтгаант өвчлөлийн тоо тогтмол өсөж байгаа хэдий ч тусламж, үйлчилгээний үндсэн бааз болох ГССҮТ-ийн мэс заслын өрөөнүүдийн орчин, тоног төхөөрөмжийн хүчин чадал олон улсын стандартаас хоцорсон, халдвар хяналт, аюулгүй ажиллагааны нөхцөл сул хэвээр байна. Тухайлбал:

- Сүүлийн үеийн мэс заслын тоног төхөөрөмж, дүрс оношилгоо эмчилгээний шийдлүүд дутмаг;
- Мэс заслын дараах сэргээн засах эмчилгээг хийхэд тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, эмчилгээний үр дүн, эдгэрэлтийг сайжруулах боломж нөхцөл хомс.

Иймд Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, үр дүнг сайжруулах зорилгоор иж бүрэн шинэчлэл хийх шаардлагатай байна.

Үндэслэл

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.1.10-т “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоонд олон улсын стандартыг мөрдүүлж, оношилгоо, эмчилгээний олон улсын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ” гэж, Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2.8-д. “Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаанд цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана” гэж тус тус заасан.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хүрээнд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа

өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгах зорилготой.

Тогтвортой хөгжлийн зорилт-3 - Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох) Монгол Улс 15.6 буюу дэлхийн дунджаас доогуур байна.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Зардал, Үр ашгийн тооцоо

Шууд зардал: Төсөлд зарцуулах нийт хөрөнгө — 7,500,000 €;

Шууд үр ашиг: Хүндрэл буурснаас хэмнэгдэх эмчилгээний зардал;

Дам үр ашиг: Хөдөлмөрийн чадвар алдалт буурснаас эдийн засагт бий болох ашиг;

Нийгмийн үр ашиг: Өвчтөн шилжүүлэх, ар гэрийн дагалдах зардал буурах.

Шууд үр ашгийн тооцоо (эмчилгээний зардлын хэмнэлт)

Мэс заслын дараах хүндрэл 10%-аар буурна:

ГССҮТ-д жилд дунджаар 16,000 мэс засал хийгддэг (сүүлийн 3 жилийн дундаж);

Хүндрэл гардаг хувь = ойролцоогоор 12–15% (ДЭМБ дундаж);

Хүндрэлтэй тохиолдлын 1 өвчтөнд зарцуулах дундаж нэмэгдэл зардал = 800 €.

Тооцоолол: Хүндрэлтэй 1920 тохиолдол 10% буурахад: 192 тохиолдол багасна.

Эмчилгээний хэмнэлт: $192 \times 800 \text{ €} = 153,600 \text{ €} / 1 \text{ жилд} /$;

Дам үр ашгийн тооцоо (хөдөлмөрийн чадвар алдалт буурах)

Сэргээн засах үйлчилгээ сайжирснаас сэргэлтийн хугацаа 20–30% буурна:

Сэргээн засах эмчилгээнд хамрагддаг гэмтлийн өвчтөн: 2,500 хүн/жил;

Ажиллах чадварын дундаж алдагдал: 45 хоног;

Шинэчлэлээс хойш буурах хугацаа: 10–15 хоног;

Монгол Улсын нэг ажилтны дундаж бүтээмжийн алдагдал (өдөр): 35 €.

Тооцоолол: $2,500 \times 12 \text{ хоног} \times 35 \text{ €} = 1,050,000 \text{ €} / 1 \text{ жилд} /$;

Гадаад урсгалыг бууруулах зардлын хэмнэлт

Гадаад улсад эмчлүүлэгчээс гарах дундаж зардал (зам, хоол, байр): 1500–2000 €;

Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чадавх, тоног төхөөрөмж, мэс заслын орчныг шинэчлэх энэхүү төсөл нь Монгол Улсад нарийн мэс засал, яаралтай тусламж, сэргээн засах эмчилгээ дотооддоо бүрэн хүрэлцээтэй болох нөхцөлийг бүлдүүлнэ. Ингэснээр гадаад руу чиглэсэн эмчилгээний урсгал 15–20% буурна. (ойролцоогоор 200 хүн).

Тооцоолол: $200 \times 1800 \text{ €} = 360,000 \text{ €} / 1 \text{ жилд} /$.

Хүснэгт 1. Нийт жилийн үр ашиг (хэмнэлт ба ашиг)

Үр ашгийн төрөл	Жил бүрийн хэмнэлт (€)
Мэс заслын хүндрэл буурснаас	153,600

Хөдөлмөрийн чадвар алдалт буурах	1,050,000
Гадаад урсгалыг бууруулах зардлын хэмнэлт	360,000
НИЙТ ЖИЛИЙН ҮР АШИГ	1,563,600 € / жил

Зардал, үр ашгийн харьцаа (Benefit–Cost Ratio, BCR)

BCR=Жил бүрийн үр ашиг / Нийт зардал
Тооцоолол: BCR=1,563,600/7,500,000=0.21

Дүгнэлт: Төсөл жил бүр нийт хөрөнгө оруулалтын 21%-ийн үр ашиг өгч байна.

Хөрөнгө оруулалтын нөхөх хугацаа (Payback Period)

Нөхөх хугацаа=Нийт зардал/ Жил бүрийн үр ашиг
Тооцоолол: Нөхөх хугацаа=7,500,000/1,563,600=4.7 жил

Дүгнэлт: Төсөл 4.7 жилийн дотор анхны хөрөнгө оруулалтаа бүрэн нөхнө.

Нэгдсэн дүгнэлт

Төсөл хэрэгжсэнээр жил бүр 1.56 сая € хэмнэлт, эдийн засгийн ашиг бий болно.
Төсөлд зарцуулах хөрөнгө 4.7 жилийн дотор нөхөгдөнө.

Мэс заслын дараах хүндрэл 30% буурснаар эмчилгээний зардал, нас баралт, хүндрэл эрс багасна.

Хөдөлмөрийн чадвар алдалт буурснаас 1 сая €-аас дээш эдийн засгийн өсөлт жил бүр бий болно.

Гадаад улсад эмчлүүлэх иргэдийн тоо 15-20%-аар мэдэгдэхүйц багасна.

---o0o---

“МОНГОЛ УЛСАД ЭХ, ХҮҮХЭД, НЯРАЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Монгол Улсад ургийн гаж хөгжлийг эрт оношилж, нярайн мэс заслын тусламж, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмж, эх, нярай, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Эх, эмэгтэйчүүдийн мэс засалд орчин үеийн шинэ технологи нэвтрүүлж, ургийн гаж хөгжлийн оношилгоог шинэ шатанд хүргэх;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлснээр ураг, нярайн мэс заслын тусламжийг сайжруулж, нутагшуулах;
- Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмжийг сайжруулах.

Төслийн хэрэгжих хугацаа: 3 жил

Төслийн байршил: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.2.16. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна;
- 2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ;
- 2.3.1. Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин:

- 1.2. Хорт хавдраар нас барсан 100,000 хүнд ноогдох тоог 2030 он гэхэд 8.0 болгон бууруулах зорилт.

Хоёр. Төслийн санхүүжилт, нөхцөл

Төслийн хүрээнд худалдан авах тоног төхөөрөмж:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Багцын үнэ
1	Эх, хүүхэд нярайн яаралтай мэс заслын тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	3,492,118.03

2	Хүүхдийн сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж	323,572.84
3	Мэс заслын хувцас хэрэгсэл угаах угаалгын тоног төхөөрөмж	301,826.70
4	Дүрс оношлогооны тоног төхөөрөмж	2,744,730.68
5	Нярайн эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж	281,030.44
6	Ясны чөмөг шилжүүлэн суулгахад хэрэглэгдэх тоног төхөөрөмж, хэрэгсэл	610,819.67
7	Хүүхэд, нярайн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын ажлын байрны, онол, дадлага хосолсон сургалт	245,901.64
НИЙТ		8,000,000.00

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд гарахаар хүлээгдэж байна:

- Ургийн гаж хөгжлийн оношилгоо шинэ шатанд хүрсэн байна;
- Ураг, нярайн мэс заслын тусламж сайжирч, нутагшсан байна;
- Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмж сайжирна;
- 0-5 насны хүүхдийн өвчлөл, эндэгдэл буурна;
- Эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, чадвар дээшилнэ;
- Хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ бий болно.

---oOo---

“МОНГОЛ УЛСАД ЭХ, ХҮҮХЭД, НЯРАЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага


Өнөөгийн нөхцөл байдал

2025 оны эхний 7 сард 31426 эх амаржиж, 31665 хүүхэд амьд, 146 ураг амьгүй төрж, төрөлт өнгөрсөн оны мөн үеэс 2115, амьд төрөлт 2132 тохиолдлоор буурсан. 2025 оны эхний 7 сард улсын хэмжээнд 100 эх хүндэрч, 90 эхийн амь нас аврагдаж, 10 эх эндэж, эхийн эндэгдлийн харьцаа 31.6 просантимил буюу 100,000 төрөлт тутамд 31.6 эх эндсэн статистик байна.

Хүснэгт 1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2021-2025 оны эхний 7 сар, Монгол Улс

ҮЗҮҮЛЭЛТ	2021 I-VII	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	2025 I-VII сар 2024 I-VII сар
Амьд төрөлт	43036	36004	38532	33797	31665	2132 тохиолдлоор буурсан
Эхийн эндэгдэл	39	14	9	6	10	4 тохиолдлоор өссөн
Эхийн эндэгдлийн харьцаа	90.6	38.9	23.4	17.8	31.6	13.8 просантимилээр өссөн
Эхийн ноцтой хүндрэл	103	101	118	103	90	13 тохиолдлоор буурсан
Эхийн ноцтой хүндрэлийн харьцаа	2.4	2.8	3.1	3.0	2.8	0.2 промилоор буурсан
Нярайн эндэгдэл	357	285	321	250	277	27 тохиолдлоор өссөн
Нярайн эндэгдлийн түвшин	8.3	7.9	8.3	7.4	8.7	1.3 промилоор өссөн
Нярайн эрт үеийн эндэгдэл	275	205	209	164	202	38 тохиолдлоор өссөн
Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин	6.4	5.7	5.4	4.9	6.4	1.5 промилоор өссөн
Нярайн хожуу үеийн эндэгдэл	82	80	112	86	75	11 тохиолдлоор буурсан
Нярайн хожуу үеийн эндэгдлийн түвшин	1.9	2.2	2.9	2.5	2.4	0.1 промилоор буурсан
Нялхсын эндэгдэл	488	444	488	410	436	26 тохиолдлоор өссөн
Нялхсын эндэгдлийн түвшин	11.3	12.3	12.7	12.1	13.8	1.7 промилоор өссөн
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	567	564	591	513	527	14 тохиолдлоор өссөн
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	13.2	15.7	15.3	15.2	16.6	1.4 промилоор өссөн
Төрөлхийн хөгжлийн гажиг	379	314	311	238	293	55 тохиолдлоор өссөн
Төрөлхийн хөгжлийн гажгийн түвшин	8.8	8.7	8.1	7.0	9.3	2.3 промилоор өссөн

2025 оны эхний 7 сард тав хүртэлх насны хүүхдийн болон нялхсын эндэгдлийн шалтгаанд перинатал үед үүссэн эмгэг (нярай), төрөлхийн хөгжлийн гажиг, амьсгалын тогтолцооны өвчин, осол гэмтэл зонхилон тохиолдсон.




Зураг 1. Эхийн эндэгдлийн харьцаа, Монгол Улс, 2020-2024 он

Хүснэгт 2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, Монгол Улс, 2021 оны I-VII сар - 2025 оны I-VII сар

Шалтгаан	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан					Нярайн эндэгдлийн шалтгаан	
	2021 I-VII	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	Амьсгалын гачаал	2025 I-VII
Перинатал үед үүссэн эмгэг	310 54.7	250 44.3	256 43.3	197 38.4	224 42.5	Тархины хүчилтөрөгчийн дутагдал	94 33.9
Амьсгалын тогтолцооны өвчин	23 4.1	71 12.6	78 13.2	85 16.6	74 14.0	Төрөлхийн хөгжлийн гажиг	42 15.2
Осол гэмтэл	58 10.2	72 12.8	74 12.5	75 14.6	67 12.7	Төрөх үеийн бүтэлт	15 5.4
Төрөлхийн хөгжлийн гажиг	94 16.6	91 16.1	112 19.0	88 17.2	85 16.1	Уушгины хатгалгаа	11 4.0
Халдварт ба шимэгчит зарим өвчин	2 0.4	9 1.6	10 1.7	7 1.4	13 2.5	Үжил	15 5.4
Мэдрэлийн тогтолцооны өвчин	16 2.8	28 5.0	18 3.0	27 5.3	32 6.1	Эх доторх халдвар	10 3.6
Хоол шингээх эрхтний өвчин	9 1.6	7 1.2	12 2.0	10 1.9	7 1.3	Гавал доторх цус харвалт	2 0.7
Хавдар	12 2.1	11 2.0	11 1.9	13 2.5	8 1.5	Гэнэтийн үхлийн хам шинж	1 0.4
Бусад	43 7.6	25 4.4	20 3.4	11 2.1	17 3.2	Төрөхийн гэмтэл	1 0.4
Бүгд	567 100.0	564 100.0	591 100.0	513 100.0	527 100.0	Нярайн хахах хам шинж	7 2.5

Зураг 2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, Монгол Улс, 2020-2024 он



Үндэслэл

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нь аливаа улс орны эрүүл мэнд, хүн амын сайн сайхан аж байдлын чухал үзүүлэлт хэмээн тооцогддог. Тогтвортой хөгжлийн

бодлого-2030 (цаашид “ТХЗ” гэх)-д бүх улс орнууд нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг тэглэх, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшнийг 25-аас доош болгон бууруулах, нярайн эндэгдлийн түвшнийг 12-оос доош болгон бууруулах зорилт тавьсан.

Хүснэгт 3. Тав хүртэлх насны хүүхдийн болон нярайн эндэгдэл, Дэлхий дахинд, 1990, 2023 он

ҮЗҮҮЛЭЛТ	1990	2023
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	93	44.6
Нярайн эндэгдлийн түвшин	36.6	17.5
Тав хүртэлх насанд эндсэн хүүхдийн тоо	12.6 сая	4.8 сая

ТХЗ-д хүрснээр тав хүртэлх насны 11 сая хүүхэд эндэхээс урьдчилан сэргийлэх боломжтой болно хэмээн тооцоолсон. Дэлхийн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 47%-ийг нярайн эндэгдэл эзэлж байна. Нярайн эндэгдлийн зонхилох шалтгаанд дутуу төрөлтийн хүндрэл, төрөлхийн хөгжлийн гажиг, төрөх үеийн хүндрэл, амьсгалын замын цочмог халдвар, үжил орж байна. Харин 29 хоногоос тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд амьсгалын замын цочмог халдвар, хумхаа, суулгалт өвчин зонхилж байна.

ТХЗ-д хүрэхийн тулд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн үндсэн хүчин зүйлсийг шийдвэрлэхэд тасралтгүй хүчин чармайлт гаргах нь чухал. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь улс орны нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс (ядуурал, эхийн боловсрол, хоол тэжээл, алслагдсан байдал), эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанартай үйлчилгээ авах зэрэг арга хэмжээг оновчтой зохион байгуулаагүй, дархлаажуулалт хангалтгүй байх зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулахын тулд хүүхдийг хөхөөр дагнан хооллох, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээг мэргэшсэн, чадвартай эрүүл мэндийн ажилтнуудад хандах, үзүүлэх, хоол, бичил тэжээлийн хангамж, хүртээмжийг сайжруулах, иргэдэд хүүхдийн өвчний үед илрэх аюултай шинжийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох, ус, ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах, дархлаажуулалтад хамруулах нь зүйтэй.

Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгохын тулд эх, эмэгтэйчүүд, хүүхэд-нярайн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх-хүүхэд-нярайн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгах нь чухал юм. Эмнэлгийн бус нөхцөлд болон сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах, хүүхдийн хавдрын өвчлөл, төрөлхийн хөгжлийн гажгийн шалтгаант эндэгдлийг бууруулах нь хөтөлбөрийн гол зорилго юм. Гэрийн эндэгдлийг бууруулах, улмаар тэглэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, хавдрын эмгэгийн үеийн эмчилгээний цогц тусламжийг бүрдүүлэх, мэдээллийн тогтолцоог бий болгох, ураг, нярайн эрт илрүүлгийн хүртээмжийг дээшлүүлж, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг дэлхийн түвшинд хүргэх, шинэ технологийг эмнэлгийн тусламжид нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Эхийн ноцтой хүндрэл, үр хөндөлт, дутуу төрөлт, амьгүй төрөлтөөс урьдчилан сэргийлснээр эхийн эндэгдлийг бууруулна. Иймд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналтын чанар,

хүртээмжийг сайжруулах, эхийн ноцтой хүндрэл, эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан, эрүүл мэндийн менежментийн асуудлыг шийдэх нь чухал.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Өндөр өртөгтэй эмчилгээ, оношилгооны үйлчилгээг дотооддоо нэвтрүүлэх, гадаад валютын урсгалыг бууруулах, иргэдийн амь нас, хөдөлмөрийн чадварыг хамгаалах.

Одоогийн нөхцөл байдлын шинжилгээ

Дээрх эмчилгээ, үйлчилгээний ихэнхийг гадаад улсад хийлгэж байгаа нь иргэд болон улсын эдийн засагт ихээхэн дарамт учруулж байна.

Хүснэгт 4. Эмчилгээ болон тохиолдлын тоо.

№	Тоногийн нэр	Өртөг тооцох эмчилгээний нэр	Тохиолдлын тоо									
			2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035
1	Өндөр өртөгтэй хагалгаа	Элэг шилжүүлэн суулгах	4	5	5	5	4	4	4	4	4	5
2		Бөөр шилжүүлэн суулгах	4	5	4	5	5	4	4	3	3	4
3		Үүдэл эс шилжүүлэн суулгах	3	3	4	4	5	4	2	3	2	3
4	Сэргээн засах	Үе мөч хэвтэн эмчлүүлэх	550	544	550	555	570	571	580	585	590	599
5		Үе мөч өдрийн эмчилгээ	535	535	600	610	611	612	620	625	630	636
6		Тархи мэдрэл хэвтэн эмчилгээ	912	912	912	912	912	912	912	912	912	912
7		Тархи мэдрэл өдрийн эмчилгээ	913	913	913	913	913	913	913	913	913	913
8	Дүрс оношилгоо	Цээжний рентген	39150	39539	39934	40000	40400	40804	41212	41628	42044	42044
9		Хөх харах -1 хөх	1880	1899	1950	1936	1955	1974	1993	2012	2032	2032
10		Хөх харах -2 хөх	1881	1900	1919	1950	1957	1976	1995	2014	2034	2034
11		Хүүхдийн ЭХО	34588	34933	35282	35634	35990	36349	36712	37079	37449	37449
12		Шүдний рентген	5040	5292	5557	5834	6126	6432	6754	7092	7446	7819
Нийт тусламж, үйлчилгээний тоо			85,460	86,480	87,630	88,358	89,448	90,555	91,701	92,870	94,059	94,450

Эдийн засгийн үр өгөөжийн тооцоо

- Гадаад улсад эмчлүүлэх зардал багасна;
- Валютын гадагш урсгал буурна;
- Нас баралт буурна;
- Хүүхдийн амьдралын чанар дээшилнэ.

Монгол Улсаас гадаад улсад элэг шилжүүлэн суулгах мэс засалд ороход БНСУ-д 400-500 орчим сая төгрөг, Энэтхэг, Турк Улсад 150-350 сая орчим төгрөгийн өртөгтэй байна. Мөн асран хамгаалагчийн зардал, бусад шууд бус зардал гардаг.

Монгол Улсад Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас Элэг шилжүүлэн суулгах өртөг-120 сая, Бөөр шилжүүлэн суулгах хагалгаа-27 сая төгрөгийн санхүүжилттэй байдаг.

Жилийн эдийн засгийн үр дүн

Австрийн хөнгөлөлттэй зээлээр тоног төхөөрөмж авснаар нийт 12 төрлийн тусламж, үйлчилгээнээс Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоосон одоогийн тарифаар тооцвол жил бүр 3.9 тэрбум төгрөгийн орлого олж, жил бүр 90,000 орчим хүүхдэд тусламж, үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөж байна.

Эрхтэн шилжүүлэх тоног төхөөрөмж нь ЭХЭМҮТ-д одоогоор байхгүй тул Улсын нэгдүгээр төв эмнэлгээс тоног төхөөрөмжийг зээлж авч хагалгаа хийдэг. Хэрэв өөрийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөр иргэдэд үйлчилгээ үзүүлбэл жилд дунджаар элэг шилжүүлэн суулгах, бөөр шилжүүлэн суулгах, үүдэл эс шилжүүлэн суулгах хагалгаануудыг 4-5 хүүхдэд хийх боломжтой болно.

Сэргээн засах эмчилгээний хувьд одоо байгаа тоног төхөөрөмждөө тулгуурлан жилд 2,900 эх, эмэгтэйчүүд, хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг байсан бол тоног төхөөрөмж нэмж авснаар жилд дунджаар 3,060 эх, эмэгтэйчүүд, хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлж, ачааллыг **10.5%-аар** бууруулах тооцоололтой байна.

Хүснэгт 5. Төсөл хэрэгжүүлснээр тусламж, үйлчилгээнд гарах үр дүнгийн талаар

№	Тусламж, үйлчилгээний нэр	Одоо		Төслийн хэрэгжүүлснээр	
		Тохиолдлын тоо	Нийт санхүүжилт	Тохиолдлын тоо	Нийт санхүүжилт
1	Өндөр өртөгтэй хагалгаа	2	147,633,445	12	915,187,531
2	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	2,500	1,393,158,000	3,060	1,529,791,600
3	Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээ	76,732	1,003,743,750	83,660	1,096,025,000
	Нийт		2,544,535,195 төгрөг		3,541,004,131 төгрөг

Мөн одоогийн байдлаар дүрс оношилгоонд жилд дунджаар 76,732 эх, эмэгтэйчүүд, хүүхдэд тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Австрийн Засгийн газрын төслөөр тоног төхөөрөмж нэмэгдсэнээр жилд 83,660 иргэнд үйлчилгээ үзүүлж, ачааллыг **10.9%-аар** бууруулахаар байна.

Эдийн засгийн үр өгөөжийн хувьд, төслийг хэрэгжүүлснээр зөвхөн эдгээр тодорхой тусламж, үйлчилгээгээр тооцоход жил бүр 1 тэрбум төгрөгөөр санхүүжилт нэмэгдэх тооцоололтой байна.

“УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжийн баазыг бүрдүүлж, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах замаар иргэдийн нас баралтыг бууруулж, амьдралын чанарыг дээшлүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд шаардлагатай дэвшилтэт технологи, өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлэх;
- Шилжүүлэн суулгах эмчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлж, хүлээгдлийн хугацааг бууруулах;
- Эмчилгээний үр дүнг сайжруулж, мэс заслын болон дараах хүндрэлийн эрсдэлийг бууруулах;
- Бөөр, элэг, зүрх, уушги зэрэг амин чухал эрхтний архаг дутагдалтай өвчтөнүүдийн нас баралтыг бууруулж, амьдрах хугацаа, чанарыг нэмэгдүүлэх;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дотооддоо өндөр түвшинд үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаадад эмчлүүлэх урсгалыг бууруулах.

Төсөл хэрэгжих хугацаа: 2 жил

Төслийн байршил: Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

• 2.2.13. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ;

• 2.2.15. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт);

• 2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

• 2.3.2.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/.

Хоёр. Төслийн санхүүжилт, төсөвт өртөг

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нийт үнэ (€)
1. Мэс заслын тоног төхөөрөмж			
1	Тромбоэстотограммын анализатор	1	42,500.00
2	Өвчтөний хяналтын монитор /эрчимт эмчилгээ/	60	1,230,000.00
3	Амьсгалын аппарат	5	308,500.00
4	Төв хяналтын монитор	6	120,000.00
5	Ясны эрдсийн нягт тодорхойлох аппарат	1	42,900.00
6	Эрхтэн шилжүүлэх хагалгааны багажны иж бүрдэл	1	173,000.00
	Нийт	74	1,916,900.00
2. Мэс засал болон эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж			
7	Отсос /эрчимт эмчилгээ/	10	40,000.00
8	Отсос /эрчимт эмчилгээ thorax	10	78,000.00
9	Тарианы автомат шахуурга /эрчимт эмчилгээ/	100	85,000.00
10	Дуслын автомат шахуурга /эрчимт эмчилгээ/	100	85,000.00
	Нийт	220	288,000.00
3. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төвийн ариутгал			
11	Уураар ариутгагч төхөөрөмж 2 хаалгатай	3	298,500.00
12	Ариутгагч, бага хэмийн, плазма, нэг хаалгатай 135 л	1	99,500.00
13	Хэт авиан ариутгагч 50 л	2	19,800.00
14	Ариутгагч (ширээн дээд тавих зориулалттай), 22 л	2	13,800.00
15	Мэс заслын багаж угааж ариутгагч, 2 хаалгатай	3	159,000.00
16	Хоёр хаалгатай хатаагч	2	36,000.00
17	Ажлын ширээ (савлах шалгах хэсэгт зориулагдсан)	5	23,250.00
18	Ажлын угсралтын ширээ	3	8,700.00
19	Ам дарагч /ширээн дээр тавих зориулалттай/	2	9,000.00
20	Тайрагч төхөөрөмж	2	1,700.00
21	Томруулагч ламп	2	1,100.00
22	Ажлын ширээ , 1.6 м (зэвэрдэггүй ган)	2	3,300.00
23	Хөтөвч угааж ариутгах төхөөрөмж	5	45,000.00
24	Урвуу осмос систем /жигжиг/	2	41,000.00
	Нийт	36	759,650.00
4. Матрас ариутгах/халдваргүйжүүлэх төхөөрөмж			
25	Матрас ариутгах/халдваргүйжүүлэх төхөөрөмж	1	574,800.00
	Нийт	1	574,800.00
5. Биологийн /эмнэлгийн хог хаягдал устгах			
26	Био аюулгүйн хог хаягдал угааж ариутгагч	2	271,000.00
27	Био аюулгүйн хог хаягдал ариутгах/ устгах	2	416,000.00
	Нийт	4	687,000.00
6. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төвийн задлангийн тоног төхөөрөмж			
28	Задлангийн ширээ	1	13,000.00
29	Задлангийн хөрөө	2	3,000.00
30	Цогцосны жин хэмжигч	2	4,000.00
31	Угаалтуур	2	10,000.00
32	Цогцос хадгалах хөргүүр (6 цогцос хадгалах)	3	72,000.00
33	Цогцос өргөгч /гидравлик/	1	11,000.00
34	Задлангийн мэс заслын сет	2	2,000.00
	Нийт	13	115,000.00
7. Эрхтэн, эд, эс шилжүүлэх төвийн дүрс оношилгооны тоног төхөөрөмж			
35	Соронзон резонанст томографийн аппарат /1.5 T/	1	2,082,450.00
36	Соронзон резонанст томографийн аппарат воркплейс	1	286,000.00

37	Ангиографи	1	1,428,500.00
38	Суурин рентген аппарат	2	514,800.00
39	Дижитал маммографи	2	357,400.00
40	Компьютерт томографи 128 зүслэгтэй	1	929,500.00
	Нийт	8	5,598,650.00
	Нийт тоо ширхэг	356	
8. Боловсон хүчний сургалт			
41	Боловсон хүчин бэлтгэх (эмч, техникч, инженерийн багийн сургалт)	1	60,000.00
НИЙТ			10,000,000.00

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Энэхүү төслийн хүрээнд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд 40 нэр төрлийн 356 ширхэг нэн шаардлагатай, эмнэлзүйн ач холбогдолтой, нотолгоонд суурилсан орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

Эрхтэн, эд, эсийн тогтолцооны эмгэгийн эцсийн үе шатанд байгаа олон эмчлүүлэгчдийн амь нас, эрүүл мэндийг аврах бодит нөхцөл бололцоог нэмэгдүүлэхэд чиглэж буй тул үнэлэх гол үзүүлэлт нь энэхүү эмчилгээний үр дүнд олон зуун хүний амь насыг аварсан бодит тоон үзүүлэлт, амьдралын чанар нь дээшилсэн иргэд байх болно. Цаашлаад эх орондоо эмчилж чадахгүй байгаа олон эмгэг өвчнийг эмчилдэг болох, мөн гадаад улс орон руу ийм төрлийн эмчилгээ үйлчилгээнд явах иргэдийнхээ явдал чирэгдэл, санхүүгийн болон сэтгэл санааны дарамтыг арилгаж гадагшаа чиглэсэн мөнгөний урсгалыг багасгана. Мөн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэхээр манай улс руу ирэх гадаад улсын иргэдийн тоо нэмэгдэнэ.

Түүнчлэн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тусламж, үйлчилгээнд оролцож буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ДЭМБ-аас дэвшүүлсэн (Resolution WHO 75. 2022) 11 зарчим болон 2018 онд шинэчлэгдэн батлагдсан Истанбулын тунхаглалын (Stanbul Decloration 2018) үзэл санаа, хууль болон ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажил үүргээ гүйцэтгэж буйг дэвшилтэт технологид тулгуурлан баримтжуулах, ил тод хяналттай шилжүүлэн суулгах систем бүрдэнэ.


---oOo---

“УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСНЫ ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага


Монгол Улсын хэмжээнд 2024 онд 10,000 хүнд ногдох амбулаторийн өвчлөлийн түвшин 10,930.9 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1,378.0-аар нэмэгдсэн ба өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд хоол боловсруулах тогтолцооны өвчин 2,010.0 (10,000 хүн амд), амьсгалын тогтолцооны өвчин 1848.9 (10,000 хүн амд) болон зүрх судасны тогтолцооны өвчин 1340.9 (10000 хүн амд) зонхилж байна.

Зураг 1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 10,000 хүн 2015-2024 он.



Мөн хүн амын нас баралт 2024 онд 18.1 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 875 хүн (4.8%)-ээр нэмэгдсэн бөгөөд нас баралтын 30,1% буюу тэргүүлэх шалтгаан нь зүрх судасны тогтолцооны өвчин 1690 (10000 хүн амд) болон хавдар 1320 (10000 хүн амд) эзэлж байна.

Зураг 2. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 2015-2024 он.




Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хэмжих нэг гол үзүүлэлт нь 30-70 насны хүн амын дунд зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын тоо үзүүлэлт юм. Монгол Улсын хувьд 2024 онд тухайн насны нас баралтын 6405 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 35.4 хувь буюу дэлхийн дунджаас хоёр дахин өндөр байгаа нь эдгээр өвчний эмчилгээний оновчтой, үр дүнтэй байдалд онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 1. Зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, 30-70 насны 10 000 хүнд, 2015-2024 он.

Үзүүлэлт	2015	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралт (30-70 нас)								
Бүгд	48.3	45.0	45.2	41.2	43.1	42.9	41.8	41.3
Зүрх судасны тогтолцооны өвчин	24.8	22.8	21.1	19.5	21.3	21.4	20.6	20.3
Хавдар	21.3	19.9	21.5	19.4	18.7	18.4	18.4	17.9
Чихрийн шижин	1.1	0.9	1.4	1.3	1.8	1.5	1.2	1.6
Амьсгалын замын архаг өвчин	1.1	1.3	1.3	1.0	1.3	1.6	1.5	1.5

Зураг 3. Зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, 30-70 насны 10 000 хүнд, 2015-2024 он.



ДЭМБ-ын статистик мэдээллээр 2022 онд 19.9 сая гаруй хүн хорт хавдраар өвдөж, 9.7 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас барж, үүний дотор Монгол Улс дэлхийд нийт хорт хавдрын нас баралт, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтаараа тэргүүлж байх ба Монгол Улсын хүн амын дунд 2024 онд 8169 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэнээс хорт хавдрын оношлогдох үеийг (TNM stage) авч үзвэл 63.4% нь хожуу үе шатандаа, үүнд гуурсан хоолой (88.5%), нойр булчирхай (79.5%), улаан хоолойн (78.6%) хорт хавдар ихэвчлэн хожуу үе шатандаа оношлогдож байгаа нь хавдар зэрэг эцсийн шатны эрхтний дутагдалтай өвчтөнүүдийн хувьд нь хамгийн үр дүнтэй, зарим тохиолдолд амь насыг аврах цорын ганц боломжит эмчилгээний арга нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ болоод байна.

Монгол Улсад эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ сүүлийн жилүүдэд хөгжиж байгаа хэдий ч дэвшилтэт тоног төхөөрөмж, нарийн мэргэжлийн хүний нөөц, дэд бүтцийн хүртээмж хангалтгүй хэвээр байна. Ялангуяа бөөр, элэг, зүрх, уушги зэрэг амин чухал эрхтний архаг дутагдлын тархалт нэмэгдэж, эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай өвчтөний тоо жилээс жилд өсөж байна. Гэвч мэс заслын хүчин чадал,

эрчимт эмчилгээний ор, хяналтын систем, нарийвчилсан оношилгооны технологийн хязгаарлалт нь хүлээгдлийг уртасгаж, нас баралтын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөн олон тохиолдолд иргэд гадаад улсад өндөр зардлаар эмчлүүлэхээс өөр сонголтгүй байгаа нь өрхийн санхүүд дарамт үүсгэхээс гадна улсын валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлж байна. Иймд дотооддоо олон улсын жишигт нийцсэн тоног төхөөрөмжийн бааз, нэгдсэн төв байгуулах шаардлага зайлшгүй тулгарч байна.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Эмнэл зүйн үр нөлөө

Дэвшилтэт тоног төхөөрөмж (эрчимт эмчилгээний мониторинг, амьсгалын аппарат, тромбоэластограм, мэс заслын микроскоп, робот бронхоскопи гэх мэт)-ийг нэвтрүүлснээр мэс заслын нарийвчлал, оношилгооны чанар, эмчилгээний үр дүн мэдэгдэхүйц сайжирна. Үүний үр дүнд мэс заслын хүндрэл, нас баралт буурч, өвчтөний амьдрах хугацаа болон амьдралын чанар нэмэгдэнэ.

Эдийн засгийн үр ашиг

Гадаадад эмчлүүлэх зардал өндөр (нэг өвчтөнд хэдэн арван мянган ам.доллар хүрдэг) байгааг дотооддоо бууруулснаар өрхийн болон улсын санхүүд хэмнэлт бий болно. Мөн валютын гадагшлах урсгал багасаж, дотоодын эрүүл мэндийн салбарын эдийн засгийн эргэлт нэмэгдэнэ. Дунд хугацаанд эрүүл хүн амын эзлэх хувь нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж өсөх нь макро эдийн засгийн эерэг нөлөө үзүүлнэ.

Нийгмийн үр нөлөө

Иргэд эх орондоо чанартай, хүртээмжтэй эмчилгээ авах боломжтой болсноор эрүүл мэндийн тэгш байдал сайжирч, нийгмийн итгэлцэл нэмэгдэнэ. Хүнд өвчний улмаас үүсэх ядуурал, санхүүгийн эрсдэл буурна.

Салбар хоорондын үр ашиг

Эмнэлгийн технологи, инженерчлэл, мэдээллийн систем, сургалтын салбаруудтай уялдан хөгжих боломж бүрдэж, мэдлэгт суурилсан эдийн засгийн суурь бэхэжнэ. Мөн олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэнэ.

Энэхүү төсөл нь зөвхөн нэг эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх бус Монгол Улсын эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний тогтолцоог бүхэлд нь шинэ шатанд гаргах ач холбогдолтой. Дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэшсэн хүний нөөц, нэгдсэн төвийн уялдааг хангаснаар амь насыг аврах, амьдралын чанарыг сайжруулах бодит үр дүн гарна. Эмнэл зүйн хувьд энэ нь нас баралтыг бууруулах, эдгэрэлтийг сайжруулах шууд нөлөөтэй бол эдийн засгийн хувьд урт хугацаанд өндөр өгөөжтэй, стратегийн хөрөнгө оруулалт гэж үнэлэгдэж байна.

“ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ГУРАВДУГААР ҮЕ ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Ард иргэд, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар олон улсын стандартын шаардлагын түвшинд хүрч, үйлчлүүлэгчид үзүүлэх эмчилгээ, оношилгооны чадавхад томоохон хэмжээний ахиц, дэвшил гарна. Цэргийн албан хаагчид өндөр мэдрэмжит шинжилгээ үйлчилгээнд хамрагдахын тулд бусад эмнэлэгт хандахгүйгээр эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр түргэн шуурхай оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ. Төслийг хэрэгжүүлснээр Цэргийн төв эмнэлэгт урд өмнө нь хийгдэх боломжгүй байсан оношилгоо, эмчилгээнүүдийг хийж, ард иргэдийн гадаад орон руу явж эмчлүүлэх урсгалыг багасгаж, эх орондоо харьцангуй хямд өртгөөр эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн Хор судлалын лаборатори;
- Цус шүүх, цэвэршүүлэх эфферент эмчилгээ;
- Бүх төрлийн уян дурангийн оношилгоо, эмчилгээ;
- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх Цусны банк;
- Эрхтэн шилжүүлэх мэс засал;
- Олныг хамарсан гамшиг, ослын амь тэнссэн үед ашиглагдах хээрийн эмнэлгийн чадамж, чадавхыг дээшлүүлэн орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх.

Төслийн хэрэгжих хугацаа: 2 жил

Төслийн байршил: Цэргийн төв эмнэлэг

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

• 2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна;

• 2.2.12. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ;

• 2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

Хоёр. Төслийн санхүүжилт, нөхцөл

№	Тоног төхөөрөмжийн багцын ангилал	Тоо хэмжээ	Нийт дүн (Евро)
1	Хор судлалын лабораторийн тоног төхөөрөмж	12	152,206.00
2	Хордлогын эфферент эмчилгээний тоног төхөөрөмж	15	386,271.00
3	Донор зохион байгуулалтын хэсэг	31	438,375.00
4	Үйлдвэрлэлийн тасаг	44	398,068.00
5	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	251	1,920,975.00
6	Эрхтэн шилжүүлэх мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	45	2,279,478.80
7	Гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл	10	296,205.60
8	Мэдрэлийн эмгэг судлалын тоног төхөөрөмж	3	180,000.00
9	Дүрс оношилгооны тоног төхөөрөмж	6	3,948,420.60
НИЙТ		417	10,000,000.00

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Төслийн хүрээнд дараах чиглэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг шинээр нэвтрүүлнэ:

- Хор судлалын лаборатори;
- Цус шүүх, цэвэршүүлэх эфферент эмчилгээ;
- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Зүрхний мэс засал;
- Мэдрэлийн эмгэгийн оношилгоо;
- Олныг хамарсан гамшиг, ослын амь тэнссэн үед ашиглагдах хээрийн эмнэлгийн орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж.

Мөн тоног төхөөрөмжийн хүчин чадал, оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэмэгдүүлэх чиглэлүүд. Үүнд:

- Гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл;
- Эрхтэн шилжүүлэх мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл;
- Бүх төрлийн уян дурангийн оношилгоо, эмчилгээ;
- Дүрс оношилгооны тоног төхөөрөмж.

Цэргийн төв эмнэлгийн Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Гэмтлийн болон Мэс заслын эмнэлзүйн төв, Яаралтай тусламжийн тасгуудын техник, тоног төхөөрөмжийн чадамж, хангалтыг өндөр хөгжилтэй орнуудын цэргийн эмнэлгийн жишигт хүргэн, Цусны банк байгуулснаар үндэсний хэмжээнд “Аврахуйн анагаах ухаан”-ы чиглэлээр тэргүүлэх, жишиг, лавлагаа шатлалын эмнэлэг болж хөгжих үндэс бүрдэнэ. Цусны банк байгуулснаар 1 жилд 300 сая орчим төгрөгийн цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн өөрийн хэрэгцээнд нийлүүлэх боломжтой болно.

Улсын хэмжээнд эм, химийн бодист хордлогод өртсөн ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах болон үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар олон улсын стандарт түвшинд хүрэх боломж бүрдэнэ.

Олныг хамарсан байгалийн болон үйлдвэрлэлийн осол, гэмтлийн үед тухайн газар оронд нь очиж аврах, яаралтай тусламжийг үзүүлэх, тээвэрлэх, эмчилж хор уршгийг арилгах боломж нэмэгдэж, тус эмнэлгийн иргэдэд үзүүлэх амь тэнссэн үеийн болон гэмтэл, мэс заслын яаралтай тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, бэлэн байдал хангагдана.

---oOo---

“ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ГУРАВДУГААР ҮЕ ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Цэргийн төв эмнэлгийн Аврахуйн анагаах ухааны салбарт Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Яаралтай тусламжийн тасгууд харьяалагддаг бөгөөд Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв нь эрчимт эмчилгээний, ерөнхий эмчилгээний, цус цэвэршүүлэх эмчилгээний үндсэн 3 тасагт нийт 55 ортойгоор улсын хэмжээний эм химийн бодисын хурц хордлогын тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Тус төвд жилд дунджаар 1500 орчим хүн эмчлэгдэж байгаагаас эрчимт эмчилгээ, яаралтай тусламжаар 400-500 орчим хүн үйлчлүүлдэг бөгөөд эдгээрийн 70% орчим нь хордлогын үеийн эрчимт эмчилгээний тусламж авдаг. Үлдэх хувь нь ерөнхий болон цус цэвэршүүлэх эмчилгээний тасгуудад эмчлэгддэг.

Хүснэгт 1. Тусламж үйлчилгээ болон тохиолдлын тоо - 2022-2024 он.

№	Тусламж үйлчилгээ	2022	2023	2024	2025
1	Эмийн хордлого	254	302	417	408
2	Химийн хордлого	116	258	271	246
3	Угаарын хордлого	726	1145	849	728
4	Архины хордлого	28	81	86	109
5	Хүйтэн зэвсэг	-	669	568	724
6	Халуун зэвсэг	-	10	8	9
7	Бусад гэмтэл	1028	659	662	1035

Дэлхийн улс орнуудын эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжил дэвшлийг даган гарч байгаа сөрөг тал нь олныг хамарсан үйлдвэрлэлийн ослууд, их хэмжээний түймэр, түүнийг дагалдан гарах угаарын, үйлдвэрлэлд хэрэглэгддэг химийн бодисуудын гаралтай хордлогууд, экологийн гаралтай хордлогууд болон орчин үеийн залуусын дунд тархаад байгаа хорт зуршил болох мансууруулах бодисын цочмог болон архаг хордлогод өртөгсдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна.

Тухайлбал Цэргийн төв эмнэлгийн Аврахуйн анагаах ухааны (Амь тэнссэн үеийн тусламж) төвд 2022 онд эм химийн болон угаарын хийн хордлогод өртөж хэвтэж эмчлэгдсэн хүний тоо 1096 байсан бол 2023 онд 1705, 2024 онд 1537, 2025 онд 1382 болж, урьд өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдэж байгаа тул Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчилж, нотолгоонд суурилсан орчин үеийн инновац шингэсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нэн шаардлагатай байгаа нь энэхүү төслийн үндэслэл болж байна.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Төслийг хэрэгжүүлснээр ард иргэд, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар олон улсын стандартын шаардлагын түвшинд хүрч, үйлчлүүлэгчид үзүүлэх эмчилгээ, оношилгооны чадавхад томоохон хэмжээний ахиц, дэвшил гарна. Цэргийн албан хаагчид өндөр мэдрэмжит шинжилгээ, үйлчилгээнд хамрагдахын тулд бусад эмнэлэгт хандахгүйгээр эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр түргэн шуурхай оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ.

Төслийг хэрэгжүүлснээр тус эмнэлэгт урд өмнө нь хийгдэх боломжгүй байсан оношилгоо, эмчилгээнүүдийг хийж, ард иргэдийн гадаад орон руу явж эмчлүүлэх урсгалыг багасгаж, эх орондоо харьцангуй хямд өртгөөр эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

---oOo---

**“ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БА ХИЛИЙН
БАРУУН, ЗҮҮН БҮСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАГАЖ, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ, СУУРИЛУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ ДАРААГИЙН ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг (цаашид “ТТАХНЭ” гэх)-ийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний чадавхыг сайжруулснаар үйлчлэх хүрээний ард иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- ТТАХНЭ-ийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлснээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, төв эмнэлгүүдийн ачааллыг бууруулах, өвчлөл, нас баралтыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх;

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, шуурхай байдлыг сайжруулж, иргэдийн хүлээгдэл, чирэгдлийг бууруулах, салбарын зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

- Орчин үеийн багаж, тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулах, тэдгээрийг ашиглах шаардлагатай стандарт орчин, өрөө тасалгааг бүрдүүлэх;

- Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг тоног төхөөрөмжийн ашиглалт болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх /богино хугацааны гадаад сургалт – 15 эмч, сувилагч, инженер, техникч; ажлын байрны дотоод сургалт – 20 эмч, сувилагч, инженер, техникч/;

- Хилийн бүс нутагт ажиллаж, амьдарч буй алба хаагчид болон хил орчмын оршин суугчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг ойртуулах.

Төсөл хэрэгжих хугацаа: 2 жил

Төслийн байршил: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг болон Хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагууд

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

• 2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна;

• 2.2.13. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ;

•2.2.14.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна;

•2.2.21.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төрөөс хараат бус бие даасан магадлан итгэмжлэлийн тогтолцоог бүрдүүлнэ;

•2.2.28.Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ;

•2.2.38.Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлж аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх боломжийг бүрдүүлнэ;

•2.2.39.Алслагдмал сум, орон нутаг, хот, нийслэлд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжинэ.

Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:

•2.2.Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг дэмжиж, хүний эрхийн баталгааг ханган, хүүхдийн хөгжил, хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг 20 хувиар өсгөнө.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

•2.3.2.6.Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.

Хоёр. Төслийн санхүүжилт, нөхцөл

Төслийн хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн жагсаалт:

№	Төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Нийт дүн (Евро)
1	Мэс заслын вакум өрөө /laminar system/	7	1,065,476.52
2	Ариутгал, угаалгын тоног төхөөрөмж	6	293,008.86
3	Дүрс оношилгооны тоног төхөөрөмж	7	3,397,528.16
4	Хоол боловсруулах, бөөр, дотоод шүүрлийн эмгэгийн тоног төхөөрөмж	2	503,646.60
5	Зүрх судасны эмгэгийн тоног төхөөрөмж	13	252,453.56
6	Мэдрэлийн эмгэгийн тоног төхөөрөмж	7	283,126.16
7	Лабораторийн тоног төхөөрөмж	6	172,252.96
8	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тоног төхөөрөмж	31	632,740.50
9	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж	15	64,758.15
10	Гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж	28	373,366.33
11	Мэс заслын тоног төхөөрөмж	41	550,261.36
12	Амбулаторийн төрөлжсөн нарийн мэргэжлийн кабинетууд	20	414,822.36
13	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээний автомашин	3	445,632.80
ТТАХНЭ			8,449,074
1	Хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж		1,084,863
НИЙТ			9,533,937

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Төслийг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашигт дараах бодит өөрчлөлтүүд гарна:

- Эмнэлгийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний хүчин чадал нэмэгдэж, жилд 200,000-аас дээш иргэнд орчин үеийн оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ. Ингэснээр үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж бодитойгоор нэмэгдэнэ;

- Орчин үеийн тоног төхөөрөмж, дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр дурангийн болон бага зүслэгтэй, нарийн мэргэжлийн мэс заслын нэр төрөл, гүйцэтгэл нэмэгдэж, нийт мэс заслын тоо 20–30 хувиар өсөх нөхцөл бүрдэнэ;

- Судсан дотуурх оношилгоо, эмчилгээ болон өндөр технологийн тусламж, үйлчилгээ дотооддоо хийгдэх болсноор төв эмнэлгүүдэд хандах урсгал 10–15 хувиар буурна;

- ТТАХНЭ-ийн хүчин чадал нэмэгдэж, төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ өргөжсөнөөр улсын төв эмнэлгүүдийн ачаалал 15–20 хувиар буурах боломж бүрдэнэ;

- Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн үйл ажиллагааг өргөжүүлснээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт 30 хүртэл хувиар нэмэгдэж, халдварт бус өвчнийг эрт үе шатанд илрүүлэх боломж сайжирна;

- Хилийн болон алслагдсан бүс нутгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирч, тусламж авахад зарцуулах цаг хугацаа, зардал буурна.

**“ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БА ХИЛИЙН
БАРУУН, ЗҮҮН БҮСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАГАЖ, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ, СУУРИЛУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ ДАРААГИЙН ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ
УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ,
ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа хил хамгаалах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, архив, оюуны өмч, улсын бүртгэл, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага, мөн шүүх, прокурор, тагнуул, онцгой байдал, авлигатай тэмцэх, гааль зэрэг байгууллагуудын алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, чөлөөнд байгаа ахмадуудад төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ, мөн Чингэлтэй дүүргийн иргэдэд гэмтэл, мэс засал, хүүхдийн тусламж, үйлчилгээ, нийт 250 гаруй мянган хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэгдсэн эмнэлэг юм.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хилийн баруун, зүүн бүсэд ажиллаж, амьдарч буй алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, ахмад хилчид, мөн хил орчмын оршин суугчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутагт эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах шаардлага тулгамдсан хэвээр байна.

Мөн эмнэлгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, оношилгоо, эмчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэхэд зайлшгүй шаардлагатай орчин үеийн дэвшилтэт технологи бүхий багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, тэдгээрийг суурилуулах, ашиглах орчныг бүрдүүлэх, шаардлагатай өрөө тасалгааг стандартын дагуу тохижуулах, эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах шаардлага үүсээд байна.

Түүнчлэн хилийн хөдөлгөөнт анги, нэгтгэлүүдэд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамруулснаар хорт хавдар, чихрийн шижин, бусад халдварт бус өвчнийг эрт үед нь илрүүлж, хүндрэлээс сэргийлэх, эмчилгээний үр дүнг сайжруулах бодит боломж бүрдэх юм.

Иймд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн хүчин чадлыг өргөтгөх, орчин үеийн тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Төслийг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашиг нэмэгдэж, Монгол Улсын нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлнэ:

Нэгдүгээрт, орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж нэвтэрснээр иргэд өндөр өртөгтэй, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг дотооддоо авах боломж нэмэгдэнэ;

Хоёрдугаарт, катетр лаборатори, дурангийн болон бага зүслэгтэй мэс заслын тусламж хөгжсөнөөр өвчнийг эрт оношлох, эмчилгээний үр дүнг сайжруулах, хэвтэн эмчлүүлэх хугацааг богиносгох, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах боломж бүрдэнэ;

Гуравдугаарт, өдрийн стационарийн үйлчилгээ хөгжсөнөөр эмнэлэгт шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тохиолдол буурч, орны эргэлт сайжирч, эмнэлгийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах нөхцөл бүрдэнэ;

Дөрөвдүгээрт, урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн хөдөлгөөнт багийн үйл ажиллагаа өргөжсөнөөр хилийн болон алслагдсан бүсийн алба хаагчид, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ойртож, хорт хавдар, чихрийн шижин, зүрх судасны өвчин зэрэг халдварт бус өвчнийг эрт илрүүлэх боломж нэмэгдэнэ;

Тавдугаарт, төслийн хүрээнд хүний нөөцийг чадавхжуулснаар эмч, мэргэжилтнүүдийн ур чадвар нэмэгдэж, шинэ технологийг тогтвортой ашиглах, засвар үйлчилгээ, ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Иймд төсөл нь зөвхөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл бус, эрүүл мэндийн салбарын чадавх, үйлчилгээний чанар, эдийн засгийн үр ашиг, бүсчилсэн хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой арга хэмжээ болно.

---o0o---

“ДУУРЬ, БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРЫН ТАЙЗ, ДУУ АВИАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилгын өнөөгийн шинж төрхийг алдагдуулахгүйгээр дотоод хүчитгэл, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах бөгөөд төслийн хүрээнд театрын тайз, гэрлийн тоног төхөөрөмж болон дуу авианы тоног төхөөрөмж, үзэгчийн суудлыг бүрэн шинэчилж, орчин үеийн сонгодог урлагийн театрын олон улсын стандартын шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.

Төсөл хэрэгжих хугацаа: 2 жил

Төслийн байршил: Дуурь, бүжгийн эрдмийн театрын байр

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

• 9.2.33.Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

• 3.3.5.8.Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ.

Хоёр. Төслийн санхүүжилт, нөхцөл

	Тоног төхөөрөмжийн нэрс	Дүн /евро/
	1.Тайзны дээд тоног төхөөрөмжийн ган бүтцийг сэргээн засварлах, өргөтгөх	827,000
1	Сараалжин давхар (grid level) болон дээд сараалжин давхар	
2	Тайзны галерейг өлгүүр болон хашлаганы хамт сэргээн засварлах	
3	Дамрын тулгуур систем, цуглуулагч дамрын тулгуур систем	
	2.Тайзны механик технологийн бүлгүүд: Тайзны дээд тоног төхөөрөмж	2,687,000
4	Хоёр хөтлөгч эргүүлэг (winch) бүхий нэг давхар нэвтрэх боломжтой портал гүүр	
5	Гэрэлтүүлгийн тавиур тус бүрт хоёр эргүүлэг бүхий гэрлийн өргүүр (hoist)	
6	Гурван цэгийн тулгуур (truss)	
7	Тайзны декорацийн өргүүр	
8	Панорама өргүүр	
9	Үндсэн хөшигний хайчин өргүүр - Грек хэв маягийн	
10	Үндсэн хөшиг өргөх механизм	
11	Хоёр хөтлөгч эргүүлэг (winch) бүхий нэг давхар нэвтрэх боломжтой портал гүүр	

	3.Тайзны механик технологийн бүлгүүд: Тайзны доод тоног төхөөрөмж	1,048,000
12	Тайзны эргэдэг тавцанг шинэчлэх	
13	Тайзны модон шал	
	4.Тайзны тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны удирдлагын систем	2,264,000
14	Дэд хуваарилалт - Цахилгаан тэжээл	
15	Сүлжээний хуваарилагч бүхий серверийн шүүгээ	
16	Дээд тоног төхөөрөмжид зориулсан моторын удирдлагын шүүгээ (MCCs)	
17	Доод тоног төхөөрөмжид зориулсан моторын удирдлагын шүүгээ (SS)	
18	Яаралтай зогсоол (E-Stop)-ын удирдлагын шүүгээ	
19	Үндсэн удирдлагын самбар CAT560	
20	Засвар үйлчилгээний удирдлагын самбар CAT530	
21	Удирдлагын самбар CAT520	
22	CAT Outlet500 самбарт зориулсан холболтын хайрцгууд	
	5.Үйлчилгээ	2,347,000
23	Газар дээрх хэмжилт болон талбайн төлөвлөгөө боловсруулах	
24	Шинэ шийдлийн төслийн хөгжүүлэлт	
25	Концепцын загварчлал болон инженерчлэл	
26	Хуучин тоног төхөөрөмжийг устгах	
27	Шинэ тоног төхөөрөмжийн тээвэрлэлт	
28	Механик угсралт болон бэхэлгээний систем	
29	Цахилгааны угсралт болон кабелийн сүлжээ	
30	Талбай дээрх хяналт	
31	Талбай дээрх удирдлага зохион байгуулалт	
32	Талбайн аюулгүй байдал ба нэвтрэх хөдөлгөөн, хамгаалах хэрэгсэл болон өндөрт ажиллах байгууламж	
	6.Хуучин системийг буулгах, устгах	224,000
33	Буулгах концепц, ажлын аргачлал, тэмдэглэгээ, үйл явц	
34	Гэрэлтүүлгийн өргүүр	
35	Тайзны декорацийн өргүүр	
36	Одоогийн сараалжин давхар болон дээд сараалжин давхар	
	7.Дагалдах хэрэгсэл болон тусгай бүрэлдэхүүн хэсгүүд	627,000
37	Үндсэн хөшиг, тусгай даавуун бүрээс	
38	Ажлын тавцан	
39	Тусгай багаж; хэмжих хэрэгсэл	
40	Үзэгчийн сандал	
	НИЙТ	10,024,000

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Энэхүү төсөл хэрэгжсэнээр дахаар үр дүн гарахаар хүлээгдэж байна. Үүнд:

- Дуурь, бүжгийн эрдмийн театр орчин үеийн дэвшилтэт технологи бүхий тайзтай болсон байна.
- Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, үзэгч, олон нийтийн сэтгэл ханамж дээшилнэ.
- Монгол Улс анх удаа дэлхийн стандартын болон аюулгүй байдлын чанарын шаардлагыг хангасан мэргэжлийн өндөр түвшний театрын тайз, чадварлаг боловсон хүчинтэй болно.
- Олон улсын уран бүтээл, уран бүтээлчид ирж тоглох нөхцөл бүрдэж, дэлхийн хэмжээний уран бүтээлийг эх орондоо үзэх боломжтой болно.
- Урын сангийн баяжилт нэмэгдэж, байгууллагын санхүүгийн чадамж сайжирч, уран бүтээлчдийн нийгмийг асуудлыг шийдвэрлэх боломж нэмэгдэнэ.

- Дэлхийд гарсан шилдэг уран бүтээлчид эх орондоо ирж тоглон, тэднийг дагасан уран бүтээл, уран бүтээлч, үзэгчийн тоо нэмэгдэж, Монгол Улсыг сурталчлан таниулах өргөн боломж нэмэгдэнэ.

Ингэснээр жилд давтагдсан тоогоор 96 удаа тоглодог байсан тоглолтын тоог 126 болгон нэмэгдүүлж, 1 тэрбум 200 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлдэг байсан орлого 30 хувиар нэмэгдэж, олон улсын чанартай тоглолт, арга хэмжээний тоо жилдээ 50 болж, дэлхийн нэр хүндтэй уран бүтээлч, уран бүтээлийг өөрийн тайзнаа тоглуулах боломж бүрдэх бөгөөд тус байгууллагын санд байгаа уран бүтээлийн ашиглалт, эргэлт сайжирч, үзэгчдийн соёл, урлагийн хүртээмж нэмэгдэх чухал ач холбогдолтой болно.

---oOo---

“ДУУРЬ, БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРЫН ТАЙЗ, ДУУ АВИАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга 1950 онд баригдсан бөгөөд тайзны тоног төхөөрөмж, гэрэл, тайзны эргэдэг тойрог болон бусад тоног төхөөрөмжүүд нь 1950-1960 онд Зөвлөлт Холбоот Улс (хуучнаар)-д үйлдвэрлэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд тайзны суурь доод эд ангийн механизм ажиллахгүй, засвар хийх боломжгүй, сэлбэг олдохгүй болсноос шалтгаалан тоглолтын үед тайзны ажиллагсад гараар буюу механикаар түрж, хөших зэргээр ажиллуулж, туухай, олс, арааг хүний хөдөлмөрөөр эргүүлж тайзыг ашиглаж байсан. Өнөөдрийн байдлаар тайз эргэхгүй зогссоноос гадна байгууллагын ажиллагсдын ажлын байрны аюулгүй байдалд эрсдэл үүсэх нөхцөл үүссэн.

Үүнээс шалтгаалан театрын урын санд байгаа уран бүтээлүүд тоглогдохгүй болж байна. Мөн тус театрт концерт, тоглолт хийхэд дуу, гэрэл, тайзны хүртээмж шаардлага хангахгүйн улмаас зарим тохиолдолд нэмэлт тоног төхөөрөмжүүдийг авчирч ашиглаж байгаа нь дуурийн театрын дуу чимээний үндсэн шинжийг алдагдуулж, үзэгч, хэрэглэгчдийн хүлээлтэд нийцсэн соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учирч байна.

Үндэслэл

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.8-д “Үндэсний сонгодог урлагийн дэг сургууль буюу заах арга зүйг магадлан итгэмжлүүлж баталгаажуулан монголын үндэсний сонгодог урлаг хэмээн дэлхийд танигдах бүтээлийг дэмжинэ” гэж, 1.1.19-д “Соёл урлагийг хүүхэд, залуучууд, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэхэд шаардлагатай театр, чуулга, соёлын ордны барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжийг шинэчилнэ” гэж, 9.2.33-т “Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.5.8-д “Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ” гэж тус тус заасан.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Дуурь, бүжгийн эрдмийн театрын тайз, гэрлийн тоног төхөөрөмж болон дуу авианы тоног төхөөрөмж, үзэгчийн суудлыг бүрэн шинэчилснээр Монгол Улс анх удаа дэлхийн стандартын болон аюулгүй байдлын чанарын шаардлагыг хангасан мэргэжлийн өндөр түвшний театрын тайз, гэрэлтүүлэг, дуу авианы төхөөрөмжтэй болоод зогсохгүй чадварлаг хүний нөөцтэй болно.

Ингэснээр жилд давтагдсан тоогоор 96 удаа тоглодог байсан тоглолтын тоо 126 болж, 1 тэрбум 200 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлдэг байсан орлого 30 хувиар нэмэгдэх, олон улсын чанартай тоглолт, арга хэмжээний тоо жилдээ 50 болж нэмэгдэх, дэлхийн нэр хүндтэй уран бүтээлч, уран бүтээлийг өөрийн тайзнаа тоглуулах боломж бүрдэж, тус байгууллагын санд байгаа уран бүтээлийн ашиглалт, эргэлт сайжирч, үзэгчдийн соёл, урлагийн хүртээмж нэмэгдэх чухал ач холбогдолтой.

Мөн энэхүү төслийг хэрэгжүүлснээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх томоохон боломжийг нээж, хамтарсан бүтээл туурвих, уран бүтээлчдийн солилцоог дэмжих, дэлхийн тэргүүлэх байгууллагуудтай түншлэл тогтоох боломжтой болно гэж үзэж байгаа бөгөөд дотоодын уран бүтээлчдийн ур чадварыг хөгжүүлэх, Монголын соёлын салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангахад шууд хувь нэмэр оруулах юм.

---oOo---